



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХӨГЖЛИЙН ХЭТӨЛБӨР**

**БАЯНХОНГОР  
2006**

## “БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР” УДИРТГАЛ

Аймгийн эдийн засаг нийгмийг алс хэтийн бодлоготой, залгамж чанартай хөгжүүлэх зорилгоор Монгол улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан “Аймгийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулав.

Баянхонгор аймаг нь Улсын бага хурлын 1941 оны 12-р сарын 11-ний өдрийн 81-р тогтоолоор 16 сум, 112 баг, 11.8 мянган өрх, 41.8 мянган хүн амтайгаар байгуулагдсан Монгол улсын нутаг дэвсгэрийн 7,8 хувийг эзэлдэг томоохон аймгийн нэг юм.

Аймгийн нутаг дэвсгэр Монгол орны Алтай, Хангай, говь, цэл, тал хээрийн гэсэн газар зүйн 4 муж, байгалийн 3 бүс, цаг агаарын 2 бусийг хамардгаараа онцлогтой. Монгол улсын нутаг дэвсгэрийн баруун төв хэсэгт байрлаж, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Архангай аймгуудтай нутаг залган БНХАУ - тай 140 км газраар хиллэх ба 116 мянган хавтай дөрвөлжин км нутагтай. Аймгийн төв нь Улаанбаатар хотоос 630 км зайдай, хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хот буюу Орхон аймгаас 700 км зайдай оршдог.

Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 19,5% буюу 2265,5 мянган га талбай улсын тусгай хамгаалалттай газарт хамрагддаг. Үүнээс дархан цаазат газар 1361,5 мянган га, байгалийн цогцолбор газар 810,7 мянган га, хилийн зурсас газар 74,5 мянган га газар эзэлдэг. Мөн алт, зэс, хар, чулуун хүрэн нүүрс, болор, жонш, гялтгануур, гантиг, боржин, шөрмөсөн чулуу шавар, шохойн чулуу элс, хайрга зэрэг Бор Овоо, Давсан тал, Бөөнцагаан, Холбоолжийн нуурын давсны ордуудтай.

Уур амьсгал, хөрсний олон бичилтэй мүжид хуваагддаг, нар салхины эрчим хүчиний нэөц сайтай, аймгийн нутгаар дэлхийн усны хагалбарын шугам дайрч өнгөрдөг, умардын хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнөдийн хэт хуурайд шилжих явцад үүсэх эрс тэс уур амьсгалтай. Агаарын температур хүйтний улиралд дунджаар -18 -30 хэм хүртэл хүйтэрч, дулааны улиралд +15 +30 хэм хүртэл халдаг, баруун хойд зүгиийн салхи зонхицлоно.

Вансэмбэруү, алтанхундага, алтангагнуур, бамбай, монгол туплин, лидэр, чихэр өвс, зээргэнэ, сөд өвс, таван салаа, гоёо, тарваган шийр, алтан утас зэрэг 100 гаруй төрлийн эмийн ургамал ургадаг.

Цээнэ, согоон чих, бадаа, мэхээр, цүлхир зэрэг хүнсний ургамал, хад, тошлой, хармаг, дэрсний бал бурам зэрэг төрөл бүрийн жимс жимсгэнээр баялаг болно. Монголд ургадаг Урал чихэр өвсний 70 гаруй хувь нь манай аймгийн нутагт ургадаг.

Аймгийн ойн сан нь нийт нутаг дэвсгэрийн 4,2 хувь буюу 490,4 мянган га талбайг эзэлж байна.

Аймгийн нийт нутагт сүүлийн олон жилийн ган, элсний нүүдэл, бэлчээрийн талхлагдал зэрэгээс цөлжилтэй явагдаж байна.

Бөөн цагаан, Орог, Дуут, Хуримт, Биндээрьяа хөх нуур, Бөөрөг, Баян нуур, Олгой, Хөх нуур зэрэг цэнгэг болон дасвтай нууруудтай, хангайн нууруунаас эх авсан Түй, Байдраг, Цагаан түүрүүт, Заг, Шаргалжуут, Харгана, Сүмбэр, Буянт зэрэг голууд голын ай савыг бүрдүүлдэг. Шаргалжуут, Үхэг, Өргөөт, Тээл, Халиут, Ичээт зэрэг халуун хүйтэн рашаантай.

Мөн улаан номонд олон төрлийн ховор ан амьттан байх ба Алтай, Хангай уулсаар аргаль, янгир, ирвэс, шилүүс, буга, гахай, хүдэр, дорго, бор гөрөөс бий. Нутгийн аль ч бүсэд тарвага, үнэг, чоно, хярс, мануул дорго зэрэг үслэг ан амьттан элбэгтэй. Тал нутагтаа хар сүүлт, цагаан зээр, мөн говийн бүсэд хар сүүлт, мазаалай, хавтгай, хулан, зэгслийн гахай зэрэг дархан цаазтай ан амьттан амьдардаг.

Баянхонгор аймаг одоо 20 сум, 100 багтай. 2004 оны эхний байдлаар 21357 өрхийн 84304 мянган хүн амтай, 1323.6 мянган толгой малтай. Судалгаанас үзэхэд манай аймгийн бэлчээрийн даац 3990,3 мянган хонин толгой байхаас „„, мянга байгаа нь бэлчээрийн нэөц байна. Баянхонгор аймаг хөгжлийнхээ түүхэнд 1999 онд 2475,1 мянган толгой мал тооплуулж монгол улсын хамгийн олон малтай аймаг болж байсан.

Одоо тус аймагт 28 ерөнхий боловсролын сургуульд 18,3 мянган хүүхэд, 2 дээд сургуульд 150 гаруй оюутан суралцдаг Баянхонгор аймагт ХААН, Монгол банк, Хадгаламж, Хас, Монгол шуудан банк зэрэг банкны салбарын нийт 30 гаруй нэгж ажиллаж байна.

2003-2005 онд цэвэрлэх байгууламж цэвэр усны нэгдсэн систем ашиглалтанд орж төвийн эрчим хүчиний нэгдсэн системд холбогдсон нь дэд бүтцийн хөгжилд сайнаар нөлөөлэх боллоо. Өвөрхангай-Баянхонгорын хооронд тавигдах сайжруулсан хайрган хүчилттэй зам баригдах ажил эрчимтэй явагдаж цаашид хатуу хүчилттэй болгох асуудал Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан байна.

Тус аймаг гадаад харилцаагаа өргөжүүлж Япон улсын Ойта мужтай “Нэг баг – Нэг шилдэг бүтээгдэхүүн” хөдөлгөөн өрнүүлэх, хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, газар тариалан эрхлэх, газрын гүний дулааныг ашиглах, орчин үеийн дэвшилтэй технологи болох компьютерийн программ болон техник хангамж зэрэг салбарт дадлагажих ажилтныг сургах, төвлөлөгч харилцан урих зэргээр няйт хамт ажиллаж байна.

Мөн Буриад улсын Кабанский районтой рашаан сувилал, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, боловсрол, соёл урлаг, спорт, хамтарсан үйлдвэр байгуулах, мал аж ахуй, тахиа, гахай, газар тариалан зэрэг салбарт хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

### **Аймгийн давуу тал:**

- Манай аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл нь хөдөө аж ахуй хэвээр байх болно.
- Орчин үеийн шинжлэх ухааны олон талын мэдлэг боловсролтой, ажиллах чадвартай боловсон хүчин, хүний нэөц төвлөрсөн.
- Зам харилцаа сайжирч эрчим хүчиний байнгын эх үүсвэрт холбогдож, цэвэр бохир усны системтэй болсон зэрэг дэд бүтцийн хөгжил сайжирсан
- Бизнесийн хувьд таатай орчин бүрдсэн зах зээлийн багтаамж ихтэй, хүний хэрэгцээг шуурхай хангах боломж сайтай.

- Эрдэс баялгийн судалгаа харьцангуй хийгдсэн, алт, нүүрс, давсны орд газруудтай.
- Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нөөц сайтай
- Газар тариалангийн үйлдвэрлэл явуулахад тохиромжтой талбай газар нутаг сайтай.
- Аялал жуулчлалын хөгжлийн үндсийг бүрдүүлсэн байгалийн үзэсгэлэнт болон түүх дурсгалын газар олонгийн боломжтой.
- Гадаад улс оронтой харилцах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломжтой.

**Аймгийн сүл тал:**

- Хөдөөд чиглэсэн дэд бүтцийн хөгжил муу, том нутаг дэвсгэрт тарж байрласан
- Жижиг, дунд үйлдвэрлэл бага хөгжсөн.
- Байгалийн бэрхшээлээс үүдэн малын тоо толгой багасч малгүй өрх олноор нэмэгдсэн
- Ядуурал, ажилгүйдэл ихээхэн газар авч, олон өрх, хүн амыг хамрах болсон
- Бус дундын болон аймаг дундын томоохон үйлдвэр байхгүй
- Зам харилцаа муугаас шалтгаалан дотоод, гадаадын тойрон аялагчид жуулчдыг татах боломж бага
- Гадаадын хөрөнгө оруулагчид тус аймагт төдийлэн сайн хандаагүй байгаа

Энэ бүх хүчин зүйлийг тооцон үзж, Монгол улсын Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр нь аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Хөгжлийн хөтөлбөр” боловсруулах ажлын хэсэг, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх талаар гаргасан бодлого, чиглэл, төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан тодорхойлон гаргалаа.

Мөн энэ хөтөлбөрийг боловсруулахдаа сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарын гаргасан саналууд, тус аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн гишүүд, эрдэмтэд, аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхний саналууд, Монгол улсын Засгийн газраас баталсан Хангай бүсийн хөгжлийн хөтөлбөр болон бусад холбогдох чиглэл, баримтлалыг нэгтгэн тусгасан болно.

Аймгийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлал нь 2006 - 2010, 2011-2015, 2016-2020 он гэсэн 3 үе шаттай хэрэгжинэ.

**БҮЛЭГ НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛЖ АЖИЛГҮЙДЭЛ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ**

**1.1 Аймгийн эдийн засгийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого**

**Үндэслэл.** Хүн амын дундаж наслалт 59, төрөлтийн нийлбэр коэффициент 2,5, жилийн дундаж өсөлт 1,3 хувь, насны голч 21,5 байгаа нь хүн амын бүтцийн хувьд залуужсан аймаг юм. Аймгаа 5 бус болгон хөгжүүлэх бодлого баримталж байна. Төвийн бүсийн төв Баянхонгор, Хангай бүсийн төв Жаргалант, тал хээрийн бүсийн төв Бууцагаан, говийн бүсийн төв Баянцагаан, Богд сум байх юм.

Хүн амын өсөлтийг одоогийн түвшинээр урьдчилан тооцвол 2010 онд 87830, 2015 онд 90674, 2020 онд 95628 хүн ам байхаар байна. Хүн амыг насны бүтцээр авч үзвэл 37,5-39,5 хувийг 20-34 насны запуу ажиллах хүчин эзэлж байна.

Аймгийн нийт бүтээгдэхүүний,,, хувийг хөдөө аж ахуй,,,, хувийг үйлдвэр үйлчилгээний салбар үйлдвэрлэж байна. Баянхонгор аймгийн нэг хүнд ногдох ДНБ нь улсын дунджаас 2.7 дахин, нэг бүсэд багтдаг Орхон аймгаас 13.2 дахин доогуур байна. Өөрөөр хэлбэл нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2004 оны байдлаар 186,7 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 283,5 мянган төгрөгөөр доогуур үзүүлэлт юм..

2004 оны байдлаар аймгийн нийт төсвийн зарлага 7,5 тэрбум төгрөгт багтаж байгаа бөгөөд нийт төсвийнхөө 14.1 хувийг татварын орлогоор бүрдүүлж, бусдыг нь санхүүгийн дэмжлэгээр нөхөж байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амаар тооцсон ажилгүйдлийн түвшин 2004 оны байдлаар 8,5 хувь, бодит ажилгүйдлийн төвшин 25,8 хувь байна.

Баянхонгор аймгийн өнөөгийн тулгамдаж байгаа асуудлууд нь ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр, дэд бүтцийн хөгжил сүл, мэдээллийн технологи бүрэн нэвтрээгүй, үйлдвэр бага хөгжсөн, төсөв санхүүгийн чадавхи дорой байдал юм.. Энэ байдлаас шалтгаалан хүн амын хот суурин луу чиглэсэн шилжилт хөдөлгөөн буурахгүй байна.

**Баянхонгор нутгаа хөгжүүлэхэд дараах тааламжтай нөхцлүүд байгаа юм.**

- Хангай говь, хээр тал хосолсон өргөн уудам газар нутагтай
- Боловсруулах үйлдвэрийн түүхий эд болох ноос, ноолуур, мах сүү, арьс шир, ангийн үс болон алт, нүүрс, давс, барилгын төрөл бүрийн материалын нөөц арвинтай.
- Байгалийн эрүүл хөрс, цэнгэг усыг түшиглэн эрүүл ахуйн шаардлага хангасан, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, орон нутгийн хэрэгцээг хангах бололцоотой.
- Сүү, махны чиглэлээр Хангайн бор сарлаг, ширүүвтэр ноост Байдраг хонь, нутгийн шилмэл омгийн ноолуурын улаан, цагаан зүсмийн ямааны цөм сургийг эрчимжсэн мал аж ахуйн хэлбэрээр өсгөн ашиг шимийг нэмэгдүүлэх боломжтой.

### **Аймгийн эдийн засгийн хөгжилд тааламжгүй нөхцлүүд байна.**

- Байgal цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, ган зуданд илүү өртөмгий, хангайн ихэнх суманд мөнх цэвдэг тархсан.
- Хүн амын хамтран ажиллах, нутаг усаараа бахархах, хайрлан хамгаалах үзэл баримтлал төлөвшөөгүй, бид гэсэн ухагдахуунаар баг болж ажиллах чадвар муутай.
- Төрөл бүрийн ашигт малтмал, барилгын материалын баялаг нөөцтэй гэх боловч урьдчилсан болон нарийвчилсан хайгуул, эрэл үнэлгээний ажил зогссон.
- Урд хөрштэй тогтмол харьцах хилийн тохижсон боомт гарц үгүйлэгдэж байгаа
- Нутаг орныхоо хөгжилд нөлөө үзүүлэхүйц томоохон, ирээдүйтэй үйлдвэрлэл эрхэлдэг үндэсний дотоодын аж ахуйн нэгж одоогоор тодрон гараагүй

#### **1.2 Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах стратегийн зорилт**

**Стратегийн зорилт 1.** Аймгийн макро эдийн засгийг хөгжүүлнэ.

**Стратегийн зорилт 2.** Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 7 хувьд хүргэнэ.

**Стратегийн зорилт 3.** Ажилгүйдлийн түвшинг жилд дунджаар 0,5-2 хувиар бууруулна.

**Стратегийн зорилт 4.** Өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулж, амьжирааг дээшлүүлнэ.

#### **Баянхонгор аймгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах хөгжлийн бодлого, стратеги**

Стратегийн зорилт	Ye шат	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
1. Аймгийн макро эдийн засгийг хөгжүүлнэ	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн давуу тал нөөцөд тулгуурлан эдийн засгийн шинэ салбар, үйлдвэрлэл үйлчилгээг бий болгох</li> <li>• Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг арилжааны даатгалд хамруулан, эрсдлээс хамгаалах бодлого баримтлах</li> <li>• Аж ахуй эрхлэгчдийг мөнгө, зээл, татварын бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутагт татах орчин бий болгох</li> <li>• Баянхонгор нутгийн нэр хаягтай бүтээгдэхүүнийн сав баглаа боодлын үйлдвэрлэл, жижиг гар урлалыг хөгжүүлэх</li> <li>• Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын үзэсгэлэн, яармаг худалдаанд оролцоход дэмжлэг туслалцаа үзүүлэх</li> <li>• Гэр бүлд зориулсан үл хөдлөх хөрөнгө, орон сууцны зээлийн тогтолцоог бүрдүүлэх</li> <li>• Ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц өндөр ур чадвартай ажиллах хүчин бэлтгэх сургалтын байгууллагуудыг бий болгож, тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, санхүүгийн дэмжлэг үзүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн төсвийг эдийн засгийн бодлоготой нягт уялдуулж, гүйцэтгэсэн бодит ажил, үйлчилгээ бүтээгдэхүүний хэмжээгээр санхүүжилтийг олгодог журамд бүрэн шилжих</li> <li>• Импортыг орлох хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл /ногоо мах сүү/-ийг хөгжүүлэх</li> <li>• Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дотоод гадаадын зах зээлд гаргах</li> <li>• Япон улсын Оита муж Солонгос улс болон ОХУ, БНХАУ-ын хил залгаа бүс нутагтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх.</li> <li>• Сумдыг бүсчлэн хөгжүүлж, бүсийн төвүүдийг эрчим хүчиний төвлөрсөн эх үүсвэрт холбох</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн хөгжлийн банк байгуулах</li> <li>• үйлдвэрлэлд зориулагдсан урт хугацаатэй хөнгөлттэй зээл бий болгох</li> <li>• Баруун аймгуудын ард иргэдийг өргөн хэрэглээний бараа, хүнсээр хангах бөөний худалдааны төвүүдийг бий болгох</li> </ul>

2. Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, нийт бүтээгдэхүүний дундаж өсөлтийг 7 хувьд хүргэнэ	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Нутаг орныхоо хөгжилд нөлөө үзүүлэхэйц томоохон ирээдүйтэй аж ахуйн нэгжийг татварын бодлогоор гадаадын хөрөнгө оруулалтаар дэмжих</li> <li>Аж ахуйн нэгж, хувиараа аж ахуйн эрхлэгчдийг ажилгүй иргэдийг ажлын байраар хангасан, дотоодын нийт бүтээгдүүний өсөлтэд хувь нэмэр оруулсан байдааар нь эдийн засгийн бодлогоор дэмжих</li> <li>“Нэг баг-нэг шилдэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг бус бүрт өрнүүлж брэнд бүтээгдэхүүнийг шинээр бий болгож дотоод гадаадын зах зээлд нийлүүлэх</li> <li>Аялал жуулчлалын өргөжүүлэн хөгжүүлэх</li> </ul> <p>Аймагтаа зээллэгийн жижиг дунд үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалангийн зэрэг сан байгуулах</p>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх</li> <li>Цахилгаан, дулаан, уур, түлш, шатахууны үнийг тогтвортой байлгах, хэмнэлттэй технологи нэвтрүүлэх бодлого хэрэгжүүлэх</li> <li>Хятад улстай хилийн гарцтай болгох асуудлыг шийдвэрлэх</li> <li>Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн орон нутгийн эдийн засгийн урамшууллын механизмыг бий болгох</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Сум бүр өөрийн нэр хаягтай нэгээс хоёр бүтээгдэхүүнтэй болж түүгээрээ дагнан хөгжих</li> <li>үндэсний үйлдвэрлэл үйлчилгээг татварын бодлогоор дэмжих</li> </ul>
3.Ажилгүйдлийн түвшинг жилд дунджаар 0,5-1 хувиар бууруулна	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн түүхий эдэд түшиглэн боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх</li> <li>Аялал жуулчлалын баазыг нэмэгдүүлэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх</li> <li>Малчны бүлэг хоршоо болон өндөр үр ашигтэй фермерийн аж ахуйг шинээр бий болгож ажлын байрыг нэмэгдүүлэх <ul style="list-style-type: none"> <li>Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж хоршоог хөгжүүлэх, төр аж ахуйн нэгжийн эдийн засгийн шинэ бүтэц бий болгож хөгжлийг сайжруулах</li> </ul> </li> <li>Ядуурал, ажилгүйдлийн талаар судалгаа хийж түүнд үндэслэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх</li> <li>Жижиг бизнес эрхлэгчид, ялангуяа эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн бодлого хэрэгжүүлэх</li> <li>Экспортод чиглэсэн боловсруулах үйлдвэрлэлийг олноор бий болгох</li> <li>Импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, аймагтаа үйлдвэрлэх боломжтой хүнс үйлдвэрлэлийг нэмэгдүүлж мөнгөний ургсгалыг дотооддоо барих бодлого баримтлах</li> <li>Эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх</li> <li>Ногоон хэрэм, ногоон байгууламж буй болгох тохижилт, зам засвар, нийтийн эзэмшлийн талбай засварлах зэрэг ажлын багтаамж ихтэй ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар нийтийг хамарсан түр ажлын байр бий болгох ажлыг зохион байгуулах.</li> <li>Байгалийн баялагийг аймгийн эдийн засагт ашигтайгаар ашиглах, байгаль хамгаалах чиглэлийн жижиг бизнесийн үйл ажиллагааг дэмжих</li> <li>Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн судалгааг нарийвчлан гаргаж, ангилан олон жил энэ ажлыг эрхэлсэн ажилгүй иргэдийг ажлаар хангаж байгаа бизнес эрхлэгчдийг дэмжих</li> <li>Хөдөлмөрийн биржийг бий болгон, ажил олгогч, ажил хайгчдын өдөрлөгийг зохион байгуулан холбох сүлжээг бий болгон хөгжүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн арга ажиллагааг боловсронгуй болгон эрчимжүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэн малыг эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлж,, мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах.</li> <li>Залуу гэр бүлийг дэмжсэн арга хэмжээг цогцоор шийдвэрлэх</li> <li>Гадны хөрөнгө оруулалтай хамтарсан үйлдвэрлэлүүдийг бий болгох, жижиг үйлдвэрлэлүүд нэгдэн хоршиж үйл ажиллагаа явуулах, хүнс, барааны томоохон сүлжээний бөөний төвүүдэд газар олгох асуудлыг бодлогоор дэмжих</li> <li>Орон нутгийн байгалийн баялаг, нөөцийн ашиглаж байгаа томоохон компани, үйлдвэрүүдийг орон нутагт үйлчилгээний салбарууд барих, үйл ажиллагааг эрхлэх, ядуу иргэдийг орон байртай болгох, ажилгүй иргэдийг ажлын байраар хангах шаардлагыг тусгасан эрх зүйн орчин бий болгон хэрэгжүүлэх</li> </ul>

	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Залуучуудын хөгжил, мэдээллийн төв байгуулан, төрөл бүрийн сургалт, үйлчилгээний байгууллагуудыг бий болгох</li> <li>Төрөлжсөн томоохон үйлдвэрүүдийг байгуулах</li> <li>Сайн дурын үндсэн дээр хөдөлмөр, хөрөнгөө нэгтгэн хоршоо, фермерийн аж ахуй байгуулсан, жижиг дунд үйлдвэрлэлийг өргтгөн ажлын байрыг нэмэгдүүлэх</li> </ul>
4. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулж амьжиргааг дээшлүүлнэ	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Хүн амд эдийн засгийн боловсрол эзэмшигүүлэх арга хэмжээ авч иргэдэд хуримтлал бий болгох сэтгэлгээг төлөвшүүлэх</li> <li>Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, газар тариалан эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах</li> <li>Ард иргэдийн мах, сүү, хүнсний хэрэглээний эрэлт хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр ханган, нийлүүлэгчдийг ажлын байр, татварын хөнгөлөлтийн бодлогоор дэмжих</li> <li>Эрчим хүч, зам тээвэр мэдээллийн сүлжээ бий болгож, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх</li> <li>Жижиг дунд бизнес эрхлэгчдэд шаардлагатай тоног төхөөрөмжийг лизенгээр олгох үйлчилгээг бий болгон хөгжүүлэх</li> <li>Орон гэргүй нэн ядуу иргэдийг орон гэртэй болгоход туслах тусгай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх</li> <li>өрх гэр бүл өөрийн өмчлөл, эзэмшилийн газар дээрээ газар тариалан эрхлэх, хүлэмж байгуулах, зоорь барих зэрэг ажил хийж, хүнснийхээ хэрэгцээг эрүүл ахуйн шаардлага хангасан өөрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах.</li> <li>өрх гэр бүлийн мэдээллийн тогтооцог бүрдүүлэх</li> <li>Малжуулах төслийг бүлэг, хоршооны хэлбэрээр хөгжүүлж, малын үүлдэр угсааг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Албан бус салбарт ажиллагсдын ажилгүй гэдэг сэтгэлгээг өөрчлөх, даатгал, татварын бодлогын ач холбогдлыг ойлгуулах, орлогоо үнэн зөв мэдээлдэг тогтолцоог бүрдүүлэх</li> <li>Ядуу өрх айл, иргэдэд зориулсан зээл, даатгал зэрэг санхүүгийн үйлчилгээг бий болгон, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалт тусlamжийг нэмэгдүүлэх түүнийг оновчтой зарцуулах, тавих хяналтыг сайжруулах</li> <li>өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд ядуу хүн өөрөө тэмцдэг үзлийг төлөвшүүлэх сургалтуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр явуулах.</li> <li>Төв суурин газрын иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан гахай, шувуу, зөгийн зэрэг таваарлаг аж ахуйг хөгжүүлэх, бүтээгдэхүүнээ боловсруулах жижиг үйлдвэрлэл бий болгоход дэмжлэг үзүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>өрх гэр бүлийн мэдээллийн системийг өргөжүүлж, гэр бүлийн хэрэгцээ, орлогыг бодитой тооцдог болох.</li> <li>Аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсийн дэмжлэгтэйгээр өрх гэр бүл, хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх</li> <li>Үнэт цаасны зах зээл, эдийн засгийн хөгжлийн төвийг бий болгон хөгжүүлэх</li> </ul>

**БҮЛЭГ ХОЁР. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ДЭД БҮТЭЦ, ХОТ БАЙГУУЛАЛТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ  
Дэд бүтцийн салбарын өнөөгийн байдал:**

Арвайхээр – Баянхонгорын 210 км-ийн өндөр хүчдэлийн шугам 2005 оны 6-р сард ашиглалтанд орсноор Баянхонгор, Эрдэнэцогт, Баян-Овоо, Өлзийт сумуудын үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагууд, аймгийн нийт хүн амын „,хувь нь байнгын цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангагдлаа. Бусад 16 сум дизель станц ажиллуулж байгаа ба цаашид говь, хангайн нилээд сумдыг төвлөрсөн сүлжээнд холбох ажил хийх шаардлагатай. Хөдөөгийн малчин өрхүүдийг сэргээгдэх эрчим хүчээр хангах ажил эхлэл тедий явагдаж нийтдээ 3000 гаруй өрх хамрагдсан байна. Аймгийн төвд эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлэх ажил хийгдлээ. Мөн цэвэр, бохир усны шугам, цэвэрлэх байгууламж ашиглалтанд ороод ажиллаж байна.

Мэдээлэл харилцаа холбооны салбарт сүүлийн үеийн шинжлэх ухаан техникийн дэвшилт нэвтэрч үүрэн телефоны мобиком, скайтлийн операторууд ажиллан интернетийн сүлжээ аймгийн төвд олон газарт үйлчилж байна.

Аймгийн төвд 2 урсгалтай хатуу хүчилттэй зам тавигдан ашиглагдах байгаа ба энэ ажил үргэлжлэн хийгдэж зарим баг, хорооны нутагт нэмж тавигдах болно. Сумдад нам даралтын уурын зуухнууд ажиллуулж аймгийн төсөвт газрууд, албан байгууллага, айл өрхүүдийг б төвлөрсөн уурын зуух бусад зарим аж ахуйн нэгж газрууд жижиг халаалтын зуухаар дулаанаа хангаж байна.

## 2.1. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР

**Үндэслэл:** Аж үйлдвэрийн хөгжил удаашралтай, жижиг хүнсний үйлдвэр голчлон хөгжик алт олборлох үйлдвэрлэлд ихэвчлэн гадны аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлж байна. Одоо аймагт талх, нарийн боовны 1 үйлдвэр, 3 цех, архины 4 үйлдвэр ажиллах замын хавтан үйлдвэрлэх, албан байгууллагын гадна тохижилт, хамгаалалтын төмөр хайс, хашаа хийх, машин техникийн засвар үйлчилгээ явуулах, ёёдол, гутал засвар хийх, бусад төрөл бүрийн үйлчилгээ явуулдаг жижиг үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна. Бумбатын тоосогын үйлдвэрийг засварлаж, жилдээ 70,0 мянга хүртэл тоосог үйлдвэрлэх хүчин чадалтай 40 гаруй ажлын байртайж жижиг үйлдвэр үйл ажиллагаа явуулж эхэллээ. Мөн аймгийн төвд блок үйлдвэрлэх цех шинээр ашиглалтанд ороод ажиллаж байна.

Шинэжинстийн Хотгор дээрс, Өвөрчулуутын нүүрсний уурхайнууд ойролцоо сум, аж ахуйн нэгжүүдэд нүүрс нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, цагаан идээ боловсруулах зэрэг аймагтаа хэрэгцээтэй шинээр үйлдвэр байгуулах асуудалд анхааран ажиллах шаардлага тавигдаж байна.

Орон нутагтаа үйлдвэрлэх бололцоотой олон төрлийн бараа, хүнсний бүтээгдэхүүнийг гадаад улс, Улаанбаатар хотоос зөөж хэрэглэж байна.

### Зорилт:

**Стратегийн зорилт:** 1. Байгалийн баялаг ашигт малтмалын нөөц бололцоонд тулгуурлан барилгын материалын жижиг дунд үйлдвэр байгуулж орон нутгийн болон бүсийн хэрэгцээг хангах.

**Стратегитийн зорилт 2.** Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх, мах, ноос, арьс ширийг үйлдвэрийн аргаар боловсруулж төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

**Стратегийн зорилт 3.** Газар тариалангийн бүтээгдэхүүнээр төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг үйлдвэрлэл хөгжүүлэх, эмийн үйлдвэр байгуулах.

**Стратегийн зорилт 4.** Хүнсний үйлдвэрүүдийн техник технологийг сайжруулан сүү, сүүн бүтээгдэхүүнээр экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

**Стратегийн зорилт 5** Эрүүл ахуй, чанарын баталгааг хангаж, сав баглаа боодлыг сайжруулан стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэн гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх ажлыг дэмжин аймгийн бренд бүтээгдэхүүн бий болгох чиглэлийг баримтлах.

**Стратегийн зорилт 6.** Үйлчилгээний салбарт машин засвар, үйлчилгээ, оношлогооны төв байгуулан ажиллуулах, нийтийн аж ахуйн үйлчилгээний жижиг үйлдвэр, цехүүдийг байгуулах

**Стратегийн зорилт. 7.** Хоршоо хэлбэрээр зохион байгуулагдсан жижиг дунд үйлдвэр хөгжих боломжийг хангах

Зорилт	Үе шат	Үйл ажиллагааны чиглэл
Байгалийн баялаг ашигт малтмалын нөөц бололцоонд тулгуурлан барилгын материалын жижиг дунд үйлдвэр байгуулж орон нутгийн болон бүсийн хэрэгцээг хангана.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>• Барилгын материалын үйлдвэрийг сэргээн засварлах</li> <li>• Цемент, шохойн үйлдвэр байгуулах</li> <li>• Жилд дунджаар 2,5 сая тоосог үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг өргөтгөл шинэтгэл хийх замаар барьж ашиглалтанд оруулах</li> <li>• Эрдэнэцогт сум, аймгийн төвд хүрмэн блок үйлдвэрлэх цехийг байгуулах</li> <li>• Шинэжинстийн Хотгор дээрний нүүрсний уурхай, Өвөрчулуутын уурхайг бүрэн хүчин чадлаар нь ашиглалтанд оруулах</li> <li>• Аймгийн төв, Шинэжинст суманд шахмал түлшний үйлдвэр байгуулах</li> <li>• Барилгын материалын үйлдвэрт технологийн шинэчлэл хийх замаар жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх ажлыг судалж хэрэгжүүлэх</li> </ul>
	2011 – 2015	<ul style="list-style-type: none"> <li>• Байгалийн баялагийг ашиглах, уул уурхайн түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>• Материал түүхий эдийн нөөцөд тулгуурласан үйлдвэрүүдийг шинээр бий болгож бус, улсын хэмжээнд бүтээгдэхүүн нийлүүлэх</li> </ul>
	2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсруулах аж үйлдвэрийн салбарт импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх</li> </ul>

<b>Стратегийн зорилт 2.</b> Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийж мах, ноос, арьс ширийг үйлдвэрийн аргаар боловсруулж төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	2006 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>Ноос, ноолуурт анхан болон дунд шатны боловсруулж, улмаар нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрийн суурь тавих.</li> <li>Цөцгийн тос, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах</li> <li>Сүү, цагаан идээ боловсруулах орчин үеийн технологи бүхий үйлдвэрийг байгуулах</li> <li>Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах</li> <li>Ингэний ундаа, рашаан савлах үйлдвэр байгуулах</li> <li>Хонины ноос боловсруулж эсгий, эсгий эдлэлийн үйлдвэр байгуулах.</li> <li>Бог малын өлөн гэдэс боловсруулж экспортонд гаргах үйлдвэр байгуулах</li> <li>Бод, богийн арьс шир боловсруулах, том шир, савхи, гутал үйлдвэрлэх жижиг үйлдвэр байгуулах төрөл бүрийн төслийг дэмжин хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</li> <li>Эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдсон сумдад сүү, цагаан идээний жижиг, дунд үйлдвэр байгуулах.</li> </ul>
	2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутаг, бүсийн хэмжээнд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үйлдвэрлэлийг хөгжүүлж нэгдсэн сүлжээг бий болгох замаар зах зээлд эзлэх байр суурийг өргөжүүлэх</li> <li>Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтарсан үйлдвэр байгуулах асуудлыг судалж хэрэгжүүлэх</li> <li>Үйлдвэрийн аргаар боловсруулсан түүхий эдээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэмжээг нэмэгдүүлэх</li> </ul>
	2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сайжруулж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</li> <li>Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шиэнэчлэх, орчин үеийн шаардлагын түвшинд бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоог нэмэгдүүлэх</li> </ul>
<b>Стратегийн зорилт 3.</b> Газар тариалангийн бүтээгдэхүүнээр төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг үйлдвэрлэл хөгжүүлэх, эмийн ургамлын үйлдвэр байгуулна	2006 – 2010	<ul style="list-style-type: none"> <li>Чихэр өвс тарималжуулан анхан шатны боловсруулалт хийх, жижиг үйлдвэр байгуулах.</li> <li>Жимс жимсгэнэ тарималжуулан төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэр байгуулах</li> <li>Эхийн голын жимс, жимсгэнэ, хүнсний ногоог дахин боловсруулах цехийн үйл ажиллагааг сэргээж өргөжүүлэх</li> <li>Үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлж автай, гурвалжин будаа, цульхир зэрэг ургамлуудаар хийдэг уламжлалт бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулах</li> </ul>
	2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>Хүнсний ногоо, жимс жимсгэнийг гэрийн нэхцөлд нөөшлөх үйл ажиллагааг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах</li> <li>Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр жимс жимсгэнэ, хүнсний ногоог дахин боловсруулах үйлдвэр байгуулах</li> <li>Аймгийн төв, тариалан зонхилох сумдад хүнсний ногоо, жимс жимсгэнэ нөөцлөх үйлдвэр цех байгуулах</li> </ul>
	2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэрийн аргаар боловсруулсан эмийн ургамлын бүтээгдэхүүнээр бүсийн аймаг, бусад зах зээлд өрсөлдөх чадвартай болох</li> <li>Үйлдвэрт боловсруулсан газар тариалангийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах</li> </ul>
<b>Стратегийн зорилт 4.</b> Хүнсний үйлдвэрүүдийн техник технологийг сайжруулан сүү, сүүн бүтээгдэхүүнээр экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	2006 – 2010	<ul style="list-style-type: none"> <li>Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх ажлыг дэмжих</li> <li>Өндөр технологи ашиглан эрүүл ахуйн шаардлага хангасан ундаа, жүүсний үйлдвэр байгуулах</li> <li>Иоджуулсан давсны үйлдвэр байгуулах</li> <li>Гурилан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах чиглэлээр одоогийн ажиллаж байгаа үйлдвэрүүдийн техник тоног төхөөрөмжийг сайжруулан шинээр үйлдвэр байгуулах санаачлагыг дэмжих</li> </ul>
	2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>Хоршоод, нөхөрлөлөөр дамжуулан сүү, цагаан идээний үйлдвэрийг сум, орон нутагт шинээр байгуулах ажлыг дэмжин хэрэгжүүлэх</li> <li>Цөцгийн тосны жижиг үйлдвэрүүдийг байгуулж сарлагийн сүүгээр хийсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх</li> </ul>

	2016 –2020	<ul style="list-style-type: none"> <li>Хүнсний үйлдвэрүүдэд шинэ техник технологи нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж ажилласнаар дотоодын хэрэгцээт гурилан бүтээгдэхүүнийг өөрсдийн үйлдвэрүүд хангадаг болох</li> <li>Шинээр үйлдвэр байгуулах, өрсөлдөөнийг бий болгох ажлыг бодлогоор дэмжин хүнсний томоохон үйлдвэрүүдтэй өрсөлдөх чадвартай дотоодын үйлдвэр байгуулах</li> <li>Аймгийн төвлүүлэх замаар үйлдвэр байгуулж төрөл бурийн бүтээгдэхүүн нийлүүлэх</li> </ul>
<b>Стратегийн зорилт 5</b> Эрүүл ахуй, чанарын баталгааг хангаж, сав баглаа боодлыг стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэр-лэн зах зээлд нийлүүлэх ажлыг эрчимтэй дэмжин явуулснаар аймгийн шилдэг брэнд бүтээгдэхүүн бий болгох чиглэлийг баримтлана.	2006 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>Төрөл бурийн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын үйлдвэрийг байгуулах санаачлагыг дэмжин төсөл тооцоо судалгаанд тулгуурлан хөрөнгө оруулалт хийх, хамтрагч талуудыг тодруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</li> <li>Аймгийн шилдэг бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд борлуулах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж нэг цэгээр үйлчлэх худалдааны тогтолцоог бий болгох</li> <li>Стандартчилал хэмжил зүйн төвийн химийн лабораторийн чадварыг сайжруулж өндөр мэдрэмжтэй хромотограф, атом шингээлтийн спектрофотометрийн аргад шилжүүлэх</li> </ul>
	2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>Хүнсний стандарт чанарыг хянан баталгаажуулах лаборатори байгуулах</li> <li>Шилдэг брэнд бүтээгдэхүүн бий болгох ажлын эхний шатны ажлыг хийж гадаад зах зээлд гаргах бодлого баримтлах</li> </ul>
	2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>Аймаг өөрийн нэрийн шилдэг бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гаргаж стандарт, чанарын баталгааг дотооддоо хийдэг болох</li> <li>Экологийн цэвэр бүтээгдэхүүнийг шаардлагад нийцсэн сав баглаа боодлоор хангаж зах зээлд гаргадаг болох</li> </ul>
<b>Стратегитийн зорилт 6.</b> Үйлчилгээний салбарт машин засвар, үйлчилгээ, оношлогооны төв байгуулан ажиллуулах, нийтийн аж ахуйн үйлчилгээний жижиг үйлдвэр, цехүүдийг байгуулна.	2006 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>Хот хоорондын зорчигчдын хүлээх танхим, тээш хадгалах байраар хангах</li> <li>Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт жижиг дунд үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжих</li> <li>Үйлчилгээний салбарт жижиг үйлдвэр, цехүүдийг байгуулах</li> </ul>
	2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>Нийтийн аж ахуйн үйлчилгээний цэг, салбаруудыг хэрэглэгчдэд ойртуулж байгуулах замаар төвлөрсөн үйлчилгээг бий болгох</li> <li>Хөдөөгийн багийн төвүүдийг бүрэн тохижуулж ахуйн үйлчилгээ, нийгмийн халамжийг ойртуулан нэг цэгийн үйлчилгээг бий болгох</li> <li>Баянхонгор сумын нийтийн тээврийн үйлчилгээний ерөнхий схем сүлжээг бий болгож иргэдэл бага болон дунд оврын автобусаар үйлчлэх</li> </ul>
	2016 – 2020	<ul style="list-style-type: none"> <li>Техникийн үйлчилгээ оношлогооны төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг өргөжүүлэн нэмэгдэл тоног төхөөрөмж оруулах замаар томоохон төв болгох</li> </ul>
<b>Стратегийн зорилт. 7.</b> Жижиг дунд үйлд-вэрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд хоршооны хэлбэрээр зохион байгуулах нэхцэл боломжийг хангана.	2006 – 2010	<ul style="list-style-type: none"> <li>Хүн амын өргөн хэрэглээний гутал, хувцас, гэр ахуйн болон ердийн хөсөг, мал аж ахуйн тоног хэрэгсэл, хадлан тэжээл үйлдвэрлэх, малчдад зориулсан ахуйн үйлчилгээ эрхлэх үүсгэл санаачлагыг дэмжих</li> <li>Үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах хоршоодын тоог нэмэгдүүлэх, төрөл бурийн төсөл арга хэмжээнд хамруулах бодлого баримтлах</li> <li>Хоршооны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон олон төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломжийг судалж хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих</li> </ul>
	2011 – 2015	<ul style="list-style-type: none"> <li>Малчдын бүлэг, хэсэг, нөхөрлөлүүдийг олноор байгуулах, үйл ажиллагааг нь дэмжих замаар хоршооны хөгжлийн бааз суурийг өргөжүүлэн жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд чиглүүлэх</li> <li>Хоршоог дэмжих сангийн хэмжээг нэмэгдүүлэх замаар хоршоодын эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг сайжруулах</li> </ul>
	2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>Хоршоодод дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн засгийн газрын болон гадаадын зээл тусламж, төсөл, хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулах</li> <li>Үйлдвэрлэл эрхлэгч хоршоодын тоог нэмэгдүүлэх, хөгжлийг сайжруулахад чиглэсэн бодлого баримтлах</li> </ul>

## 2.2 . ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР

### ҮНДЭСЛЭЛ

Баянхонгор аймгийн төв нь 2005 оны 5-р сард ТЭХС-д холбогдож Баянхонгор аймгийн төв, Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумууд, Шаргалжуут рашаан сувилал тосгоны нийт 6000 гаруй айл өрх, 3000 гаруй албан газар, аж ахуйн нэгжүүдийг ЦЭХ-ээр тасралтгүй найдвартай хангадаг боллоо

Баянхонгор хотод баригдсан 110/35/6 кв-ын дэд станцад сууринлагдсан трансформатор нь 6300 кВа хүчин чадалтай. Одоогийн нийт ачаалал 2500 кВт байна.

Станцын 9 гаргалгаанаас 10 кВ-ын 54.7 км, 6 кВ-ын 93.2 км ЦДАШ, 10/04 кВ-ын 3 дэд станц, 6/04 кВ-ын 41 дэд станцаар дамжуулан хэрэглэгчдээг ЦЭХ-ийг түгээдэг юм.

Дэлхийн банкны "Нам хүчдэлийн шугам сүлжээний алдагдал бууруулах" төслөөр Баянхонгор аймгийн төвийн гэр хорооллын 8 дэд станцын 71 км шугам сүлжээг иж бүрэн шинэчлэн модон тулгуурыг бетон хөлтэй болгож, агаарын хөнгөн цагаан шугамыг агаарын бүрээстэй кабель СИП-ээр сольж шинэчлэн 3500 айл өрхөд электрон тоолуурыг 3 тай 6 тай хайрцагт тавьж монтажласнаар техникийн болон техникийн бус алдагдлыг энэ объектод 5% хүртэл бууруулсан болно.

Мөн Жаргалант сумын ЭХС-ын дизель станцаас /100 станц 2, 60 станц 1 ш /Заг /25 км/ Гурванбулаг /55 км/ сумдыг 10 кВ-ын ЦДАШ-аар дамжуулан ЦЭХ-ийг түгээж байна.

-Галуут, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмараал, Баянбулаг, Баатагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст, Баянговь, Баянлиг, Богд, Жинст сумуудад Японы 100. 60 моторууд сум тус бүрд 2-3 ш сууринлагдсан бөгөөд оройд 4-5 цаг ажиллаж байна.

#### Стратегийн зорилт:

1. Аймгийн эрчим хүчний системийг зохистой өргөтгөх, төв суурин газрын цахилгаан болон дулааны хямд найдвартай эх үүсвэртэй болгох, суурь судалгааг хийнэ.

2. Байгаль орчинд халгүй үр ашигтай эрчим хүчний техник технологийг нэвтрүүлж үйлдвэрлэл хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх, хөдөөгийн малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

3. Нар, салхины эрчим хүч ашиглан цахилгаан үйлдвэрлэх системийг судалж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Зорилт	Үе шат	Үйл ажиллагааны чиглэл
1. Аймгийн Эрчим хүчний системийг зохистой өргөтгөх, төв суурин газрын цахилгааны болон дулааны хямд найдвартай эх үүсвэртэй болгох, суурь судалгааг хийнэ	2006 - 2010	<ul style="list-style-type: none"><li>• Баянхонгор хотын цахилгаан шугам сүлжээг шинэчлэн сайжруулах</li><li>• Баянхонгор-Бөмбөгөр-Загийн чиглэлийн 35 кВ-ын 180 км урт ЦДАШ-ийг барих</li><li>• Хотгор дэрсний нүүрсний уурхайг түшиглүүлж нүүрс-хийн цахилгаан станц барих</li><li>• Баянлиг, Баянговь, Баян-Өндөр, Баянцагаан сумдад сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр барих</li><li>• Баянбулаг суманд нар-дизель хосолсон сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр барих</li><li>• Баруун Баян улаан-Богд, Жинстийн 83 км урт 15 кВ-ийн ЦДАШ-ийг барих</li><li>• Баянхонгор-Баян-Овоо чиглэлийн ЦДАШ-ийг өргөтгэх Баян-Овоо-Галуутын чиглэлийн 58 км 15 кВ-ийн ЦДАШ-ийг барих</li><li>• Бөмбөгөр-Бууцагаан-Хүрээмараалын чиглэлийн 120 км урт 15 кВ-ийн ЦДАШ-ийг барих</li><li>• Бөмбөгөр-Баатагааны чиглэлийн 85 км урт 15 кВ-ийн ЦДАШ-ийг барих</li><li>• ЦЭХ-ний техникийн болон техникийн бус алдагдлыг бууруулан ард иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжийг ЦЭХ-ийг зөв зохистой үнэн зөв шударга хэрэглээнд сургах</li><li>• Ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ЦЭХ-ний хэрэглээг нэмэгдүүлэх, системийн тогтвортой байдлыг хангах үүднээс урьдчилсан төлбөрт болон 3 тариift тоолуурыг нэвтрүүлж хэрэглэгчдийг урамшуулж, тэдэнд ЦЭХ-ний үнийн дарамтыг бууруулах арга хэмжээ авах</li><li>• Шаргалжуутын халуун рашааны бүсийг тогтоож 10 мВ-таас доошгүй хүчин чадалтай геотермал станц барих суурь судалгааг хийж хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэх</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Төвлөрсөн дулаан хангамжийн систем барих суурь судалгааг хийж зураг төслийг боловсруулан хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх</li> <li>Түй, Байдраг болон бусад жижиг голууд дээр бага оврын усан цахилгаан станц барих боломжийг судлах</li> <li>Богд, Жаргалант, Гурванбулаг, Заг, Галуут сумдыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох</li> </ul>
2. Байгаль орчинд халгүй, үр ашигтай Эрчим хүчний техник, технологийг нэвтрүүлж үйлдвэрлэл хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх, хөдөөгийн малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>"Буман нарны гэрэл" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж хөдөөгийн бүх малчин өрхийг нарны эх үүсгүүрээр хангах</li> <li>Шаргалжуутын халуун рашааны бусэд хийсэн суурь судалгааны үндсэн дээр 10 мВт-аас доoshгүй хүчин чадалтай станц барыж ТЭХС-д холбох</li> <li>Баянхонгор аймгийн төвд төвлөрсөн дулаан хангамжийн систем барих</li> <li>Түй, Байдраг болон бусад жижиг голууд дээр нийлбэр хүчин чадал нь 500 кВт-аас доoshгүй бага оврын УЦС барих</li> <li>Салхины Эрчим хүчийг ашиглах, нөөц нь тогтоогдсон газруудад дунд чадлын /30-5 мВт/ салхин паркууд байгуулах суурь судалгааг бүрэн хийх</li> <li>Говийн бусэд өндөр хүчин чадалтай нарны цахилгаан станц байгуулах олон улсын хамтарсан судалгааг хийх.</li> <li>Нарны илчээр ус, агаар халаах арга технологи, тоног төхөөрөмжийг барилга байгууламжийн дулаацуулга, хэрэглээний халуун ус болон бусад зориулалтаар өргөн ашиглах Ус төрөгч, тулшиний элемент зэрэг эрчим хүчиний шинэ эх үүсвэрийг ашиглан дулаан цахилгаан үйлдвэрлэх техник технологийг судалж нэвтрүүлэх.</li> </ul>
3. Нар, салхины эрчим хүч ашиглан цахилгаан үйлдвэрлэх системийг судалж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	2016 -2020	<ul style="list-style-type: none"> <li>Салхины эрчим хүчиний суурь судалгааны үндсэн дээр салхины эрчим хүч ашиглан эрчим хүч үйлдвэрлэх дунд чадлын парк байгуулж системд холбох</li> <li>Говийн бусэд өндөр хүчин чадалтай нарны цахилгаан станц байгуулан системд холбох</li> <li>Шинээр байгуулагдсан салхины парк болон нарны цахилгаан станцад системд холбогдоогүй нар-салхи-дизель хосолсон сэргээгдэх эрчим хүчиний эх үүсгүүрээр ажиллаж байгаа сумдыг холбох</li> </ul>

### 2.3 ХАРИЛЦАА ХОЛБОО МЭДЭЭЛЭЛ

#### Үндэслэл:

Баянхонгор аймгийн Холбооны газар нь Өвөрхангай аймгийн 111-р станцаас Скайтелийн тоон РРШ-аар дамжсан 2МВ-ын урсгалаар УБ хотын АТС-45-тай, мөн тус аймгаас Mobicom-ын нэг тоон урсгалаар Е-10 станцын ургсгалтай холбогдож , нийт 60 сувгийн гарцаар улс, хот хоорондын телефон яриа, факс, интернет зэрэг үйлчилгээг явуулж байна. Эдгээр гарцыг дамжуулж байгаа сүлжээ аймгийн Холбооны газраас 115-р станц хүртэл 16km шилэн кабель, Урс-115 р станцаас Өвөрхангай РРШ-ын Урс – 111 -р станц хүртэл ТРРШ-аар дамжих байна. Аймгийн төвөөс улс хот хоорондод холбогдох сүлжээ нь үндсэндээ тоон технологийг шилжсэн боловч хурд багтаамжийн хувьд хүрэлцээ муутай байна,

Аймгийн төвөөс сум хооронд бүхэлдээ аналоги технологитой сүлжээ ашиглаж байгаа бөгөөд Релейний шугамын дагуу ердөө 2 сум л тоон технологийг бүхий 2 сувагтай байна. Орон нутгийн холбоонд агаарын шугамын няятуулгын ОВ-3-3, ОВ-12-3 системүүд болон ган шугамаар 20 сум сууринг аймгийн төв болон улс, хот хоорондтой холбож байна.

Баянхонгор аймгийн төвөөс Жаргалант Баянбулагийн чиглэлд 278 km бронз шугам, Баянлигийн чиглэлд 219km БСА шугам, Баянцагааны чиглэлд 246 km АС шугам нийтдээ 743 km өнгөт шугам, бусад сумуудын чиглэлд нийт 645 km ган шугамаар холбогдсон бөгөөд агаарын баганат шугамын нийт урт-1081 km байгаа юм.

Эдгээр шугамаар Баянхонгор- Жаргалантын хооронд ОВ-12-3 системээр, Баянхонгор-Баянцагааны хооронд мөн ОВ-12-3 систем, Баянхонгор-Баянлиг, Баянхонгор-Баянбулагийн хооронд ОВ-3-3 системээр тус тус няятуулагдан Жаргалант , Баянцагаан тус бүр 7 суваг, Баянлиг, Баянбулаг тус бүр 3 суваг ялгаруулан ашиглаж байна. Эдгээр сумууд нь няятуулагдсан сувгийн 66%-ийг эзэлж байна. Аймгийн төвийн хэрэглэгчид үүрэн телефоны үйлчилгээ авах боломжтой байгаа нь нийт хэрэглэгчийн 25% -т эзлэж байна, Интернетийн үйлчилгээ үндсэндээ хөгжөөгүй эхлэлийн төдий 20 гаруйхан хэрэглэгчтэй байна,

**Стратеги зорилт 1.** Цахилгаан холбооны суурь сүлжээг шинэчилж өргөн зурсасын өндөр хурдны сүлжээнд нэгдэнэ.

**Стратеги зорилт 2.** Сумын төвийн холбооны систем болон аймаг сумын хооронд дамжуулах системийг тоон

технологт бүрэн шилжүүлнэ.

**Стратеги зорилт 3.** Холбооны үйлчилгээнд хиймэл дагуулын болон бага багтаамжийн РРШугам , хөдөлгөөнт холбооны систем нэвтрүүлнэ.

**Стратеги зорилт 4.** 2015 онд суурин телефоны нягтралыг 8,52 т хүргэнэ.

**Стратеги зорилт 5.** Малчдыг интернет ашиглах боломжтой болгоно.

**Стратеги зорилт 6.** Үүрэн телефоны хэрэглэгчдийг бүсийн хүн амын 40 хувьд хүргэнэ.

**Стратеги зорилт 7.** Мэдээллийн сүлжээг бүхэлд нь байгуулж нийтийн сүлжээнд холбогдоно.

**Стратегийн зорилт 8.** Телевизийн нэвтрүүлгийн үйлчлэх хүрээ сувгийн тоог нэмэгдүүлж мэдээллийн хангамжийг сайжруулна.

#### **Баянхонгор аймгийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжлийн зорилт, чиглэл.**

<b>Зорилт</b>	<b>Үе шат</b>	<b>Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл</b>
1. Цахилгаан холбооны суурь сүлжээг шинэчилж өргөн зурсасын өндөр хурдны сүлжээнд нэгдэнэ.	2006 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>Эхний ээлжинд Өвөрхангай-Баянхонгорын хоорондох РРШ-ын тоног төхөөрөмжийг тоон технологид шилжүүлэх</li> <li>Өвөрхангайгаас Баянхонгор хүртэл 220 км шилэн кабелийн сүлжээ байгуулах</li> </ul>
2. Сумын төвийн холбооны систем болон аймаг сумын хооронд дамжуулах системийг тоон технологт бүрэн шилжүүлнэ.	2006 – 2010	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн төвийн ойролцоо сумуудыг WWL холбоогоор холбоожуулах</li> <li>Сумын төвийн холбох байгууламж тэжээлийн системийг дэс дараатайгаар бүрэн шинэчилэх</li> </ul>
	2011 – 2015	<ul style="list-style-type: none"> <li>○ Сумын төвийн холбох байгууламж тэжээлийн системийг дэс дараатайгаар бүрэн шинэчилэх ажил үргэлжлэх</li> </ul>
	2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн төвөөс 4 бүсийн төв рүү шилэн кабелийн болон сансрын холбооны сүлжээ байгуулах</li> </ul>
3. Холбооны үйлчилгээнд хиймэл дагуулын болон бага багтаамжийн РРШугам , хөдөлгөөнт холбооны систем нэвтрүүлнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Бүсийн төвүүдийг сансарын холбооны болон бага багтаамжийн РРШ-тай болгох</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Зарим сумдад хөдөлгөөнт холбооны систем тавих</li> <li>Бүсийн төвүүдийг сансарын холбооны болон бага багтаамжийн РРШ-тай болгох ажил үргэлжлэх</li> </ul>
	2016 -2020	<ul style="list-style-type: none"> <li>Сумдад хөдөлгөөнт холбооны систем үргэлжлэн тавих</li> </ul>
4. 2015 онд суурин телефоны нягтралыг 8,52 т хүргэнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн төвийн АТС-ийн багтаамжийг аажмаар нэмэгдүүлж цэгийн тоог 2400-д хүргэх</li> <li>Зарим сумдын төвийг дэс дараатайгаар АТС-тэй болгож нэгдсэн сүлжээнд холбох</li> </ul>
	2011- 2015	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн төвийн АТС-ийн багтаамжийг аажмаар нэмэгдүүлж цэгийн тоог 3000-д хүргэх</li> <li>Бусад сумдын төвийг дэс дараатайгаар АТС-тэй болгож нэгдсэн сүлжээнд холбох</li> </ul>
5. Малчдыг интернет ашиглах боломжтой болгоно.	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Сансарын холбооны систем ашиглах</li> <li>Хөдөлгөөнт холбооны системийг сумдад бий болгох</li> </ul>
6. Үүрэн телефоны хэрэглэгчдийг бүсийн хүн амын 40 хувьд хүргэнэ.	2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>Үүрэн телефоны операторуудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</li> </ul>

7. Мэдээллийн сүлжээг бүхэлд нь байгуулж дэлхий нийтийн сүлжээнд холбогдоно.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн төвийн байгууллагууд зарим сумыг интернетийн болон дотоод мэдээллийн сүлжээнд холбох</li> <li>Аймгийн төвд интернетийн үйлчилгээний операторын үйлчилгээг бий болгох</li> </ul>
	2011 – 2015	<ul style="list-style-type: none"> <li>Сумуудыг интернетийн сүлжээнд дэс дараатай холбох</li> </ul>
	2016 - 2020	Сумуудыг интернетийн сүлжээнд дэс дараатай холбох ажил үргэлжлэн хийгдэх
8. Телевизийн нэвтрүүлгийн үйлчлэх хүрээ сувгийн тоог нэмэгдүүлж мэдээллийн хангамжийг сайжруулна.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн төвийн хэрэглэгчдийг олон сувгийн нэвтрүүлэг үзэх боломжоор хангах</li> <li>Сумын төвүүдийг олон сувгийн нэвтрүүлэг үзүүлэх боломжоор хангах</li> </ul>
	2010 - 2015	Сумын төвүүдийг олон сувгийн нэвтрүүлэг үзүүлэх боломжоор хангах
	2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>Аймаг өөрийн телевизийн студи, нэвтрүүлэгтэй болох</li> </ul>

## 2.4 ХОТ БАЙГУУЛАЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАР

### Үндэслэл

Аймгийн төвийн ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээт цэвэр усыг хоёр гүний худгаас хлораторын байгууламж, контор везервуар, түгээх шугамаар дамжуулан барилгажсан хэсгийн бүх объектод 4,8 км шугамаар хүргэж байна. Гэр хорооллын иргэдэд гүний 4 худгаар 14 усан сан 2 автомашинаар түгээж усны хэрэглээний 60 орчим хувийг хангаж байна. Албан газар, хүн амаас хоногт дунджаар 363,4 м куб усыг татан зайлцуулж, ариутгах татауургад цэвэрлэгээ хийж байна. Мөн нийтийн эзэмшилжин зориулалттай 31 орон сууц, түүнд 607 өрхийн 1731 хүн амьдарч нэгдсэн үйлчилгээнд хамрагддаг хувийн 9 орон сууц ашиглагдаж эдгээр нь бүгд цэвэр ус, ариутгах татуургын системд бүрэн холбогдсон. Цэвэр усны хэрэглээний ..... хувийг, бохир усны гаргалтын ..... хувийг тус тус үйлдвэрлэл үйлчилгээний газар эзэлж байна. СӨХ албан ёсоор байгуулагдаагүй “Чандмань” ХХК –ийг түшиглэн ажиллаж байна. Гэр хорооллын хог тээврийн машин байхгүй, хог хаягдлын цэг ундны усны эх үүсвэрийн дээд талд байрласан, зэрлэг хог хаягдал их тархсан зэрэг бэрхшээлүүд тулгамдсан асуудал болж байна.

### Стратегийн зорилт

**Стратегийн зорилт 1.** Хот байгуулалт, НАА-н салбарыг бэхжүүлэн улсын үйлчилгээг шаардлагын түвшинд хүргэх

**Стратегийн зорилт 2.** Нийтийн аж ахуйн үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх.

**Стратегийн зорилт 3.** Хүн амын амьдрах орчинг сайжруулж, иргэдэд таатай амьдрах нөхцлийг бүрдүүлэх.

**Стратегийн зорилт 4.** Орчин үеийн шинэ дэвшилтэй техник, технологи нэвтрүүлэх

**Стратегийн зорилт 5.** Техникийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн байгууллагуудтай хамтран зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилчидтай болох

Зорилт	Үе шат	Үйл ажиллагааны чиглэл
Хот байгуулалт, НАА-н салбарыг бэхжүүлэн улсын хэмжээний шаардлагын түвшинд хүргэнэ.	2005 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>40000 айлын орон сууцны хөтөлбөртэй уялдуулан орон сууц барих хөдөлгөөнийг бүх талаар дэмжих</li> <li>Шинээр бий болох орон сууцны бичил хороолол болон барилгажилттай холбогдон шинэ шугам сүлжээг бий болгох.</li> <li>Сууц өмчлөгчийн холбоог оновчтой зохион байгуулж, үйл ажиллагааг жигдруүлэн хэвийн ажиллагааг хангах, санхүүгийн чадавхитай болгох</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Баянхонгор хотод шаардлагатай нийтийн бие засах газар байгуулах</li> <li>Хогийн төвлөрсөн цэгийг шинээр бий болгох</li> <li>Хог хаягдлыг ашиглаж үйлдвэрлэл явуулах</li> <li>Гэр хорооллуудад эрүүл ахуйн шаардлага хангасан усан сан байгуулах</li> <li>Гэр хорооллыг гидроклонк болон ариутгах татуургын шугам хоолойд холбох.</li> </ul>
Нийтийн аж ахуйн үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэнэ.		<ul style="list-style-type: none"> <li>Гэр хороололд ус хангамжийн шугам бий болгосноор иргэдийг хэрэглээний шаардлага хангасан усаар хангах</li> <li>Нэг метр куб усны өөрийн өртгийг бууруулах чиглэлийн арга хэмжээ авах</li> <li>Баянхонгор хотын оршин суугчдыг тохилог орчинд амьдрах бололцоо нөхцөлөөр хангах зорилт тавин ажиллах</li> </ul>
Хүн амын амьдрах орчинг сайжруулж, иргэдэд таатай амьдрах нөхцлийг бурдуулэнэ.		<ul style="list-style-type: none"> <li>Баянхонгор хотын баруун талаар ариутгах татуургын шугам хоолой шинээр байгуулах</li> <li>40000 айлын орон сууцны хүрээнд шинээр баригдах орон сууцны ус хангамж, ариутгах татуурга, дулааны эх үүсвэрүүд байгуулах</li> </ul>
Орчин үеийн шинэ дэвшилтэй техник, технологи нэвтрүүлнэ.		<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны дэвшилтэй уялдан шинэ техник, технологи ашиглан бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулах, ололтой арга ажиллагааг үйлдвэрлэлд нэвтрүүлэн ажиллах</li> </ul>
Техникийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн байгууллагуудтай хамтран зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажил-чидтай болно.		<ul style="list-style-type: none"> <li>Техникийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургуультай гэрээтэй хамтран ажиллах сургалтын баазыг бий болгох</li> <li>Орчин үеийн техник технологийн ололтыг ажилчдад байнга танилцуулж, ажлын байран дахь сургалтыг явуулж байх</li> </ul>

## 2.5. ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

**Үндэслэл:** Аймгийн нутаг дэвсгэрээр Говь-алтай чиглэлийн ..... км, Шаргалзут чиглэлийн, ..... улсын чанартай авто зам дайрч өнгөрдөг. Орон нутгийн чанартай ..... км авто зам байна. Арвайхээр – Баянхонгорын авто замыг дэлхийн банкны хөрөнгөөр сайжруулах ажил дуусч байна. Аймгийн төвийн замыг өрөнхий төлөвлөгөөний дагуу барих ажил удааширалтай байна. Өдөр шөнийн аль ч цагт онгоц хүлээн авах гэрэлтүүлэг бүхий хатуу хучилттай зурвастай. Аймгийн ачаа, зорчигч, хот доторхи тээврийг хувийн салбар гүйцэтгэж байна.

Аймагт аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт хийгдэж, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг жуулчны бааз байхгүй байна. Улаанбаатар хотоос дулааны улиралд нүүдлийн маягаар Баянговь суманд гарч ажилладаг жуулчны гэр баазаас өөр ямар нэгэн үйлчилгээний салбар хөгжөөгүй байна.

Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мастер төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллах, энэ салбарын хөгжлийг түргэтгэх, төрийн бодлогоор дэмжин ажиллах хэрэгтэй байгаа юм.

### Стратегийн зорилт:

- Авто замын нөхцлийг сайжруулна.
- Хотын доторхи замыг хотын өрөнхий төлөвлөгөөний дагуу барьж байгуулна.
- Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулж, энэ салбарыг шинээр бий болгон хөгжүүлнэ.
- Тээвэр зохион байгуулалтыг сайжруулна.

Д/д	Зорилт	Үе шат	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1.	1. Авто замын нөхцлийг сайжруулна.	2006 – 2010	<ul style="list-style-type: none"> <li>Арвайхээр–Баянхонгорын чиглэлийн авто замыг бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хайрган хучилттай болгох</li> </ul>
		2011 – 2015	<ul style="list-style-type: none"> <li>Арвайхээр Баянхонгорыг холбосон замыг хатуу хучилттай болгох</li> </ul>
		2016 – 2020	<ul style="list-style-type: none"> <li>Шивээ хүрэнгийн боомтын үйл ажиллагааг өргөжүүлэн Бага-Илбэнхийн боомтоор дамжин гарах босоо тэнхлэгийн замыг барьж эхлэх</li> </ul>

	2. Хотын доторхи замыг хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу барьж байгуулна.	2006 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>Арвайхээр Баянхонгорыг холбосон замыг хатуу хучилттай болгоход холбогдо замуудыг сайжруулах</li> <li>Баянхонгор сумын 7-р багийн нутагт үерийн хамгаалалт барих</li> <li>Аймгийн төвд 1,05 км-ийн асфальтан зам тавих</li> <li>Баянхонгор сумын 5-р багийн нутагт 1 км явган хүний зам тавих</li> </ul>
		2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн чанартай замуудыг сайжруулж зарим гол, даваанд замын сангийн хөрөнгөөр гүүр тавих, засч сайжруулах</li> <li>Аймгийн төвд үргэлжлүүлэн хатуу хучилттай зам тавих</li> <li>Зарим баг, хорооны нутагт авто болон явган хүний зам тавих ажил үргэлжлэх</li> </ul>
		2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн төв, суурин газарт шинээр зам тавих ажлыг үргэлжлүүлэх</li> <li>Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу шаардлагатай газарт хотын дотор зам тавих ажлыг үргэлжлүүлэх</li> </ul>
	3. Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулж , энэ салбарыг шинээр бий болгон хөгжүүлнэ.	2006 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт хийхийг дэмжих</li> <li>Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулан мөрдэх ажиллах</li> <li>Шаргалжуут рашаан, Баянговийн Бүгийн хоолой, Галуутын хавцал, Гурванбулагийн Хөх нуур зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр маршрут гарган тогтоож үйл ажиллагаа явуулах</li> </ul>
		2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>Жуулчлалын мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх</li> <li>Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн хөгжлийг сайжруулах</li> <li>Аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдож хөгжүүлэх</li> </ul>
		2016 - 2020	<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх</li> <li>Шаргалжуут рашааныг түшиглэн олон улсын амралт сувиллын төв байгуулах</li> <li>Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж жуулчдыг жилийн 4 улиралд хүлээн авах боломжтой олон улсын жишиг, стандартад нийцсэн баазуудыг байгуулах</li> </ul>
		2006 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийх оношлогооны суурин станцад тээврийн хэрэгсэл бүрийг бүрэн хамруулж улсын нэгдсэн сүлжээнд холбогдох</li> <li>Авто тээврий хот хоорондын, орон нутгийн болон хотын доторхи гэсэн чиглэлээр хөгжүүлж Баянхонгор сумын нийтийн тээврийн үйлчилгээний ерөнхий схем сүлжээг бий болгох</li> </ul>
	4. Тээвэр зохион байгуулалтыг сайжрууна.		<ul style="list-style-type: none"> <li>Тээврийн хэрэгслийн ашиглалтын байдал стандартад тавих хяналтыг өндөржүүлнэ.</li> <li>Алслагдсан сум суурин газарт явуулын үзлэг оношлогоо хийх, техникийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх</li> <li>Хот хоорондын зорчигчдын хүлээх танхим, тээш хадгалах байраар хангах</li> </ul>
		2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Авто тээврийн салбарын улс ба хот хоорондын ачаа, зорчигч, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээг хөгжүүлж, орон нутгийн тээврийн салбарын хөгжлийг тогтвортжуулна.</li> <li>Техникийн хяналтын үзлэг оношлогооны төвийг нэмэгдэл тоног төхөөрөмжөөр ханган, мэдээллийн сүлжээг өргөжүүлнэ.</li> <li>Баянхонгор сумын нийтийн тээврийн үйлчилгээний ерөнхий схем сүлжээг бий болгож, иргэдэд үйлчилгээг ойртуулна.</li> </ul>
		2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Зам харилцаа сайжирснаар хот хоорондын зорчигч тээвэрт дунд болон том оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлнэ.</li> <li>Авто тээврийн салбарт ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг сайжруулснаар техник технологийн дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ.</li> </ul>

## БҮЛЭГ ГУРАВ. БОЛОВСРОЛ СОЁЛЫН САЛБАР

Үндэслэл:

Аймгийн Боловсрол соёлын газар нь 28 сургууль, 26 цэцэрлэг, 19 соёлын төвийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. ЕБС-ийг 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх сургалтын шинэ төлөвлөгөөний дагуу шаардлагатай багш нарын судалгааг сургууль цэцэрлэг бүрээр нарийвчлан гаргаж 2005-2006 оны хичээлийн жилд 760 багш ажиллаж байгаа нь хүргэцээ хангамж 96,8 хувьтай байна. Аймгийн хэмжээний 7-15 насны 17417 хүүхдээс 16336 хүүхэд ЕБС-д суралцаж хамран сургалт 94 хувьд хүрлээ. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт ердийн бүлэгт 33,5 хувь, хувилбарт сургалтанд 27,8 хувьтай болж байна. Цаашид боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, сургалтын агуулга дахь онол дадлагын харьцаанд өөрчлөлт оруулахад багш нарын сургалтын хөтөлбөр, төлөвлөлтийг бүтээгч хандлагатай болгох, мөн мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжилтэй холбогдож, компьютерийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, нэн ялангуяа хөдөөгийн 8 жилийн сургуулиудыг дижитал төхөөрөмжөөр хангах, ЕБС-иар мэргэшүүлэх, гүнзгийрүүлэх сургалт явуулахад бодлогоор дэмжлэг үзүүлэх, их дээд сургуулиудтай хамtran ажиллах, төгсөж ирсэн боловсон хүчиний тогтвортой ажиллуулах урамшууллын механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.

### Стратегийн зорилт.

**Стратегийн зорилт:** 1. Боловсролын тогтолцоо болон сургалтын байгууллагын хэв шинжийг боловсронгуй болгож үндэсний хөгжлийн хөтөлбөрт дэвшүүлсэн түвшинд хүргэнэ

**Стратегийн зорилт 2.** Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх

**Стратегийн зорилт 3.** Суралцагсдад чадварт суурилсан мэдлэг эзэмших сургалтын агуулга, технологи нэвтрүүлэн хувь хүний хөгжлийг хангах гол хөшүүрэг болгох

**Стратегийн зорилт:** 4. Бүх шатны сургууль боловсролын байгууллагын сургалтын материаллаг орчныг сайжруулж иргэдийн боловсрол олж авах таатай орчныг бүрдүүлэх.

**Стратегийн зорилт:** 5 Олон улсын нийтлэг жишигт ойртон АББ-ын нээлттэй тогтолцоо бүрдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролын хэрэгцээг хангах

**Стратегийн зорилт:** 6 Техникийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн байгууллагуудын сургалтын чанарыг сайжруулан зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэх

**Стратегийн зорилт:** 7. Орон нутгийн түвшинд шинжлэх ухааны чадавхийг бэхжүүлж, бүтэц, менежментийг сайжруулах.

Зорилт	Үе шат	Үйл ажиллагааны чиглэл
1. Боловсролын тогтолцоо болон сургалтын байгууллагын хэв шинжийг боловсронгуй болгож үндэсний хөгжлийн хөтөлбөрт дэвшүүлсэн түвшинд хүргэнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>• Бага, дунд боловсролыг 11 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх</li> <li>• Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан ЕБС-ийн байршил, хэв шинж, бүтцийг шинэчлэн тогтоох</li> <li>• Сургалт үйлдвэрлэлийн дадлагын газрууд бухий бүрэн дунд сургуулиудыг бий болгох</li> <li>• Хүүхдэд ээлтэй сургууль, цэцэрлэгийн орчин бүрдүүлэх</li> <li>• Алсын зайны сургалт болон мэдээлэл холбооны технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх</li> <li>• Хувилбарт сургалт бухий СӨБ-ыг байгуулах</li> <li>• Бусад орны жишиг сургууль байгуулахыг дэмжиж ажиллах</li> </ul>
	2011 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлийн сургалттай ахлах сургуулийг бий болгож бодлогын хэмжээнд дэмжиж ажиллах</li> <li>• Бага, суурь, ахлах, мэргэшүүлэх сургууль гэсэн дагнасан бүтэцтэй болох</li> <li>• Тусгай хэрэгцээт боловсролын анги, бүлэг бий болгох</li> <li>• ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн бүтэц, хэв шинжийг олон улсын жишигт хүргэх</li> <li>• Бүх түвшний сургалтанд хувийн хэвшлийн эзлэх байр суурь, хамрах хүрээг нэмэгдүүлэх</li> <li>•</li> </ul>
	2016 – 2020	<ul style="list-style-type: none"> <li>• ЕБС-д зайны сургалтын тодорхой сүлжээ бий болгох</li> <li>• Мэдлэг олж авах үйл явцыг анги бүлгийн хэв шинжээс гадна сонирхолын бүлгийн хэлбэрээр өргөжүүлэх</li> </ul>

2. Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах үндсэн хувилбарт, олон хэлбэрийг ашиглан СӨБ-ын хамралтыг 60 хувьд хүргэх</li> <li>ЕБС-ийн хамран сургалтыг 95 хувьд, тусгай хэрэгцээт боловсролын хамрагдагсадыг 60 хувьд хүргэж, бүх иргэдийн дотор бичигтэн иргэдийн эзлэх хувийг 99.5 хувьд хүргэх</li> <li>Хүүхдийн эрүүл мэндийн боловсрол үйлчилгээний төвийг сургууль, түшиглэн байгуулах</li> <li>Суралцаачдын дүнгийн нууцлалыг хадгалах суралцаач эзэмшилийн түвшингөө өөрөө хянаж зохих түвшний боловсрол эзэмшдэг тогтолцооны эхлэлийг тавих</li> <li>Хосолсон болон хөрвөх чадвартай багшийн тоог нэмэгдүүлэх чиглэл баримтлан багшийн хөгжлийг хангах</li> <li>Мэргэжлийн багшийн хангамжийг бүрэн шийдвэрлэх</li> <li>Багшах боловсон хүчиний судалгааг 15 жилийн хугацаагаар жил жилээр гаргаж нөхөн хангалтыг тооцон ажиллах</li> <li>Багшах авьяас сонирхолтой хүүхдэд багш мэргэжлийн бэлтгэлийг олгодог “Багш” сонгоны бүлгийн элсэлтийг нэмэгдүүлж сургалтын чанарыг сайжруулах</li> <li>Бүрэн дунд сургуульд заавал судлах хичээл, аль нэг судлагдахууныг заавал сонгон судлах хичээлийг оруулж суралцаач бүрэн дунд сургуулиас ирээдүйн мэргэжлийнхээ бэлтгэлийг хангах, бололцоог олгох</li> <li>Багш нарын мэргэжлийг үндэсний хэмжээнд, орон нутагт, ажлын байранд гэсэн 3 түвшинд дээшлүүлэхээс гадна мэдээлэл харилцааны технологийг ашигласан зайны сургалтыг өргөн нэвтрүүлэх</li> <li>ЕБС-ийн насны хүүхэд 100 хувь сургуульд хамрагдах боловсролын орчны чадамжийг бий болгох</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Багшийн стандартыг гаргаж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх</li> <li>Сум сургуулийн гэрээ захиалгаар багш бэлтгэдэг уламжлалыг өргөтгөн сум сургууль өөрийн хэрэгцээт багшаа бэлтгэдэг тогтолцоонд шилжих</li> <li>СӨБ-ын хамралтын хувийг 80 хувьд хүргэх</li> <li>ЕБС-ийн хамран сургалтыг 98 хувьд, тусгай хэрэгцээт боловсролын хамрагдагсадыг 80 хувьд хүргэж, бүх иргэдийн дотор бичигтэн иргэдийн эзлэх хувийг 99.8 хувьд хүргэнэ.</li> <li>“Багш” мэргэжлээр суралцаачдад сум, сургууль, аймгийн тэтгэлэг олгох арга хэмжээ авах.</li> <li>Ерөнхий боловсрол олгох үйлчилгээ олон хэлбэрийн сургалттай танхимины, зайны, шавилах, хөдөлмер- дадлагад суурilsan /гэх мэт/ байх</li> <li>Багш, сурагчид гадаад оронд суралцаах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх боломж бүрдүүлэх</li> <li>Сургууль бүр вэб сайттай болох</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Багшийг давтан сургах асуудлыг орон нутагтаа шийдэх, орчин нөхцөлийг бүрдүүлж багшийн хөгжлийн нээлттэй төв байгуулах</li> <li>СӨБ-ын хамралтын хувийг 90 хувьд хүргэх</li> <li>ЕБС-ийн хамран сургалтыг 100 хувьд, тусгай хэрэгцээт боловсролын хамрагдагсадыг 80 хувьд хүргэж, бүх иргэдийн дотор бичигтэн иргэдийн эзлэх хувийг 100 хувьд хүргэх</li> <li>Суралцаачдын мэдлэг чадварыг үнэлэх үнэлгээний олон улсын стандартыг нэвтрүүлэх</li> <li>Хүүхдэд гэрээр нь үйлчлэх багштай болох</li> </ul>

3. Суралцагсад чадварт суурилсан мэдлэг эзэмших сургалтын агуулга, технологи нэвтрүүлэх нь хувь хүний хөгжлийг хангах гол хөшүүрэг болно.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Бага, дунд боловсролын стандартад нийцсэн орон нутгийг тусгасан сургалтын хөтөлбөртэй болох</li> <li>Бүрэн дунд сургууль төгсөгчид нь дотоод, гадаадын аль ч их дээд сургуулийн элсэлтийн шаардлага хангахуйц мэдлэг, чадвар эзэмших агуулгыг хэрэгжүүлэх</li> <li>Сургалтын төлөвлөгөөнд дараах өөрчлөлт оруулан бага боловсролд 6 чиглэлийн 10 судлагдахуун, суурь боловсролд 6 чиглэлийн 19 судлагдахуун, бүрэн дунд боловсролд 7 чиглэлийн 18 судлагдахуун судлах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийг оюуны чадамжаар нь сургаж аль болох бие дааж хөгжихийц сургалтын технологи нэвтрүүлэх</li> <li>Англи хэлийг 4-р ангиас, мэдээлэл зүйн судлагдахууныг бага боловсролоос эхлэн судалж, бүрэн дунд сургуульд 2-3 гадаад хэл сонгон судлуулах</li> <li>Олон улсын боловсролын болон сургуулиудын вэб ашигладаг болох</li> <li>Хичээл хоорондын интеграци, нэгдмэл чанарыг хангаж хүүхдэд амьдрал хэрэглээний цогц чадамж төлөвшүүлэх</li> <li>Сургалтанд шашны боловсролын агуулгыг оруулах</li> <li>Мэдээлэл холбооны технологийн үсрэнгүй хөгжлийг ашиглан албан ёсны болон албан ёсны бус сургалтын мэдээллийн багтаамж, хүртээмжийг нэмэгдүүлэх</li> <li>Мэдээлэл харилцааны технологийг сургалтанд өргөн нэвтрүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээлэл холбооны технологи ашиглан зайнлас суралцах нөхцөл бүрдүүлэх</li> <li>Олон улсын жишигт нийцсэн загвар сургууль бий болгох</li> <li>Дэлхийн боловсролын жишигт нийцсэн агуулгад бүрэн шилжиж тогтвортой мөрдөх нөхцөл бүрдэж түршлага хуримтлуулах</li> </ul>
4. Бүх шатны сургууль боловсролын байгууллагын сургалтын материаллаг орчныг сайжруулж иргэдийн боловсрол олж авах таатай орчныг бүрдүүлнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Сургуулийн болон дотуур байрны барилгыг ээлж дараалалтай бүрэн засварлах</li> <li>Баянхонгор аймгийн төвд 4-р 10 жилийн сургуулийг ашиглалтад оруулах.</li> <li>Сургалтын үлгэр жишээ орчинтой загвар сургууль байгуулах</li> <li>Сургалтын ширээ сандал бусад хогшлыг аймагтаа үйлдвэрлэх нөхцөл бүрдүүлэх</li> <li>Суралцагчдын мэдлэг чадварыг үнэлж дүгнэх өндөр чадвар бүхий машинуудыг нэвтрүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн боловсрол соёлын газар, бусийн төв сургуулиудын сургалт судалгааны баазыг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</li> <li>Аймгийн төвд гадаад хэл, орон нутаг судлалын төв байгуулах</li> <li>Мэдээлэл холбооны технологийн иж бүрэн / зайны сургалтын студи, интернет, дижитал тоног төхөөрөмжтэй / төв байгуулах</li> <li>Хүүхдийг хөгжүүлэх амралт чөлөөт цагийн болон туршилт судалгаа, ажиглалтын орчинг цогцолбор шинжтэй байгуулах</li> <li>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэцийн оношлогооны төв, зарим сургуулиуд дээр сургалт арга зүйн төвүүд байгуулан ажиллуулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Сурагчид сургуульдаа ирэх, харих аюулгүйн нөхцөлийг хангаж гэрээсээ сургуульдаа явах нөхцөл бүрдүүлж унаагаар үйлчлэх боломжийг судлах</li> <li>Мэдээлэл харилцааны өндөр чадал бүхий техник хэрэгслээр тоноглогдсон явуулын мэдээллийн төвийн үйлчилгээ бий болгох</li> <li>Баянхонгор хотод хүүхдийн номын ордон байгуулах</li> </ul>

5. Олон улсын нийтлэг жишигт ойрсон АББ-ын нээлттэй тогтолцоо бүрдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролын хэрэгцээг хангана.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>АББ, зайны сургалтын тогтолцоог боловсронгуй болгон менежментийг сайжруулан дуэл затварыг гэгээрлийн төвийн 60 хувьд хэрэгжүүлэх</li> <li>АБС, зайны сургалтын орчны стандартыг тогтоож, түвшинг тодорхойлох шалгууртай болох</li> <li>АБС, зайны сургалтын үйлчилгээний механизмыг боловсронгуй болгосноор иргэдэд өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд, амьдрах ухаанд суралцах сургалтын оновчтой загвартай болох</li> <li>Иргэдийн бичиг үсгийн боловсролын түвшинг цогцоор дээшлүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулж монгол, крилл, латин үсгийн боловсролын түвшинг 20 хувь ахиулах</li> <li>АБС, Зайны сургалтын боловсон хүчиний чадавхи, нөөцийг сайжруулж орон нутгийн төвлөрсэн, бусчилсэн, ажлын байрандаа бие дааж суралцах хэлбэрүүдээр тэдний ур чадварыг нэмэгдүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>АБС, Зайны сургалтын тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлж аймгийн төвд иргэдийн хөгжлийн нээлттэй төв, сумдад нээлттэй гэгээрлийн төвүүдтэй болох.</li> <li>Хувийн FM, орон нутгийн телевизээд сургалтын сувагтай болох</li> <li>Хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгсэлээр боловсролын тогтмол нэвтрүүлэг явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэн гэрээгээр ажиллуулан зайны сургалтын хүртээмжийг 25 хувь нэмэгдүүлэх</li> <li>Сургалтын мэдээллийн сүлжээг бий болгосноор суралцагч өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн бие даан суралцагчдын эзлэх хувийг 30 хувь нэмэгдүүлэх</li> <li>Бичигтнийг чадваржуулж функциональ бичигтэн болгох дээд түвшний сургалтыг тасралтгүй зохион байгуулж бага мэдэгч, үл мэдэгчтүй болох суурийг тавих</li> <li>Баянхонгор суманд амьдрах ухаан мэргэжлийн баримжаа олгох сургалт явуулах “Хүн хөгжил” алба ажиллуулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>АБС, зайны сургалтын нээлттэй их сургуулийн суурь тавих</li> <li>Тасралтгүй боловсролд зориулсан радио, телевизийн цагтай болох</li> <li>АБС, зайны сургалт явуулах хувийн хэвшлийн сонирхолыг дэмжин өрсөлдөөн бий болгох</li> <li>Функциональ бичигтний эзлэх хувь 90 хувь болох</li> <li>Томоохон байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилтан ажилчдынхаа тасралтгүй боловсролын хэрэгцээг хангах сургалтын төвүүдтэй болох</li> <li>АБС, зайны сургалтын боловсон хүчин, удирдах ажилтан бэлтгэдэг салбарыг орон нутгийн дээд сургуулиудад нээх</li> </ul>
6. Техникийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн байгууллагуудын сургалтын чанарыг сайжруулан зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилчин бэлтгэнэ.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын оновчтой бүтэц, хэв шинжийг тогтоох</li> <li>Мэргэжлийн сургалттай ахлах сургуулиудыг байгуулах</li> <li>MCYT-ийн орчин үеийн техник технологи эзэмшсэн үйлдвэр аж ахуйн газарт ажиллах чадвар бүхий мэргэжилтэй ажилтан бэлтгэх чадамжтай болгох</li> <li>Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг интернетийн сүлжээнд холбох</li> <li>Техникийн болон мэргэжлийн сургуулийн сургалтын орчныг сайжруулж сургалтын техник хэрэгсэлийг шинэчлэн боловсон хүчиний чадавхийг сайжруулах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Техникийн болон инженерийн дээд боловсролтой боловсон хүчинийг түлхүү бэлтгэх бодлого баримтлах</li> <li>Сургалт хөдөлмөрийн интеграцилал бий болгох</li> <li>Ерөнхий боловсрол- мэргэжлийн сургалт- дээд боловсролын хоорондын уялдааг сайжруулан боловсролын системийн янз бүрийн үе шатыг интеграцчлах</li> <li>Техникийн болон мэргэжлийн сургалтын менежментийг боловсронгуй болгох Мэргэжлийн сургалтын агуулгын стандартын шалгуурыг тогтоох</li> </ul>

	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Техникийн болон инженерийн дээд боловсролтой боловсон хүчнийг түлхүү бэлтгэх бодлого баримтлах</li> <li>Сургалт хөдөлмөрийн интеграцилал бий болгох</li> <li>Ерөнхий боловсрол- мэргэжлийн сургалт- дээд боловсролын хоорондын уялдааг сайжруулан боловсролын системийн янз бүрийн үе шатыг интеграцлах</li> <li>Техникийн болон мэргэжлийн сургалтын менежментийг боловсронгуй болгох</li> <li>Мэргэжлийн сургалтын агууллын стандартын шалгуурыг тогтоох</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн сургалттай сургуулийн тоог нэмэгдүүлж тэдгээрт суралцагчдын тоог ахлах сургуулийн суралцагчдын 25-аас доошгүй хувьд хүргэх</li> <li>Фермерийн аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн салбарт ажиллах мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургууль шинээр байгуулах</li> <li>Мэргэжилтэй ажилчдын чадавхийг олон улсын жишигт хүргэх суурийг тавих</li> <li>Мэргэжлийн зөвлөгөөн өгөх төв бий болгох</li> </ul>
7. Орон нутгийн түвшинд шинжлэх ухааны чадавхийг бэхжүүлж бүтэц, менежментийг сайжруулна	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого боловсруулах алба байгуулах</li> <li>Аймгийн ЗДТГ-ын дэргэд эрдэмтэд судлаачдын зөвлөл ажиллуулах</li> <li>Орон нутгийн хөгжилд өндөр хувь нэмэр оруулсан эрдэмтэд бүтээлч сэхээтэнд олгодог шагнал бий болгох</li> <li>Орон нутагт ажиллаж байгаа дээд сургуулиудыг их сургуулийн стандартад хүргэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны судалгааны төв байгуулах</li> <li>Аймагт бие даасан шинжлэх ухаан технологийн дээд сургууль байгуулах</li> <li>Орон нутагт эрдэмтэд тогтвортой ажиллан, судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээ үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх</li> <li>Шинжлэх ухаан технологийн зорилтот сан байгуулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны судалгаа мэдээллийн сан, сүлжээ бий болгож нээлттэй танхим байгуулах</li> <li>Орон нутгийн эрдэм шинжилгээний лаборатори байгуулах</li> <li>Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг дэлхийн жишигт хүргэж чанартай мэргэжилтэн бэлтгэх</li> <li>Шинжлэх ухааны мэдээлэл солилцох электрон сүлжээнд холбох</li> </ul>

## БҮЛЭГ ДӨРӨВ. МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, БАЙГАЛЬ ОРЧИН ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХӨГЖИЛ

### 4.1 Хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал:

Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 13363 малтай өрх, 1323646 толгой мал тоологдож, тэмээ 1,5 хувь, адуу 5,0 хувь, үхэр 6,5 хувь, хонь 28,0 хувь, ямаа 59,0 хувийг тус тус эзэлж байна. Өндөр ашиг шимт малын эзлэх хэмжээ хонинд 4,7, ямаанд 0,5, үхэрт 0,03, тэмээ, адуунд шилмэл омгийн малын тоо хувь эзлэхээргүй байна.

Аймгийн малчин өрхийн 82,0 хувь нь 100 хүртэл толгой малтай байгаа нь малчин өрхийн амьдралын баталгаа доогуур болохыг харуулж байгаа юм. Нөгөө талаар нийт 24,0 мянган малчин байгаагийн 13,7 мянга буюу 57,1 хувь нь 16-34 насны залуу малчид эзэлж байна.

Газар тариалан, мал аж ахуй хосолсон фермерийн аж ахуй хөгжөөгүй байна. Мал аж ахуйн материаллаг баазын бэхжилт хангалтгүй байгаагийн дотроос хонин толгойд шилжүүлсэн нэг толгой малд 0,5 тэжээлийн нэгж тэжээл бэлтгэх байгаагаас үзэхэд хадлан тэжээл бэлтгэх байгалийн нэхцэл бололцоо хангалтгүй, бэлчээрийн даацтай уялдуулан малын тоо толгойг тохируулан малладаггүй, малчдын идэвхи санаачилга жигд биш байгаатай холбоотой. Нэг хунд ногдох мах, гурил, будаа, сүү, сүүн бүтээгдэхүүн нь хүнсний зүйлийн бүтэцд 88,4 хувийг эзэлж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний чанарын шаардлага хангалтгүй байгааг харуулж байна.

Баянхонгор аймагт ширүүтвэр ноосны "Байдраг" үүлдэрийн хонь, "Залгаа жинстийн цагаан", "Нутгийн шилдэг омгийн ямаа" Бөмбөгөрийн "Өлзийт голын улаан" зэрэг цэвэр үүлдрийн болон нутгийн үүлдрийн малыг үржүүлэн сайжруулагчаар ашиглаж байна. Дээрхи үүлдрийн болон омгийн мал, сайжирсан суурь сүрэг нь нийт сүргийн 20,5 хувийг эзэлж байна. Одоогийн байдлаар хувийн хэвшлийн 32 аж ахуйн нэгж мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг эрхлэж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга

хэмжээнд 1,3 сая паразит өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 1,1 сая, лабораторийн шинжилгээ, оношилгоонд 45,0 мал хамруулж жилд 130 гаруй сая төгрөгийн эм био бэлдмэлийг зарцуулж байна.

### **Стратегийн зорилт**

**Стратегийн зорилт. 1:** Мал аж ахуй газар тариалан хосолсон, хагас суурин эрчимжсэн өрхийн болон фермерийн аж ахуйн материаллаг баазыг орчин үеийн шаардлагат хүргэн бэхжүүлж хөгжүүлнэ.

**Стратегийн зорилт. 2:** Нутгийн үүлдрийн малын үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

**Стратегийн зорилт. 3:** Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх.

**Стратегийн зорилт. 4:** Малчин өрх болон малыг эрдлээс хамгаалах арга хэмжээг малчид төрийн хамтарсан үйл ажиллагааны дунд авч хэрэгжүүлнэ.

**Стратегийн зорилт. 5:** Мал амьтны халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар хүртээмжийг сайжруулна.

<b>Зорилт</b>	<b>Үе шат</b>	<b>Үйл ажиллагааны чиглэл</b>
1. Мал аж ахуй газар тариалан хосолсон, өрхийн болон фермерийн аж ахуйн материаллаг баазыг орчин үеийн шаардлагат хүргэн бэхжүүлж хөгжүүлнэ	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Хагас суурьшсан өрхийн аж ахуйн хэлбэрийг судлан газар дээр нь үзүүлж судлуулах, сургалт явуулах зэргээр малчдын үйл ажиллагаанд нэвтрүүлэх</li> <li>Малчдын саналыг үндэслэн хамтран ажиллах бүлэг байгуулан тэдгээрт хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж сум бүр нэгээс доошгүй загвар фермер байгуулах</li> <li></li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Хашаалсан хадлан бэлчээрийн усалгаатай тариалан эрхлэх, талбайг бордох, олон настын үр үржүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах зэргээр газарт хөрөнгө оруулалт хийсэн малчдыг зүйл бүрээр хөхүүлэн дэмжих</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Хадлан тэжээл бэлтгэдэг бага оврын техник тоног төхөөрөмжийг малчид тариаланчдад урт хугацаатай, бага хүүтэй зээл, түрээс лизэнгийн хэлбэрээр олгох, орон нутагт өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бурдуулэх</li> </ul>
<b>Зорилт 2.</b> Нутгийн үүлдрийн малын үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Уламжлалт бэлчээрийн мал маллагааг хагас суурьшлын мал маллагааны аргатай хослуулан хөгжүүлж нутгийн үүлдрийн малыг өөр дотор нь шилж сонгон цэвэр үржүүлгийн аргыг хэрэглэхээс гадна нутгийн үүлдэр омгийн малаар эрлийзжүүлэх ажлыг хослон хэрэгжүүлж үржүүлдэг болох</li> <li>Хангайн сумдад сарлагийг бэлчээрийн мал маллагааны нөхцөлд маллаж цэвэр үржүүлгийн аргаар үржүүлж сарлаг олонгой Эрдэнэцогт, Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг, Өлзийт, Баянбулаг сумдад зонхилон Хэрэгцээний чиглэлээр гибриджүүлгийн арга хэрэглэж хайнагжуулах ажлыг зохион байгуулах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Монгол үүлдрийн үхрийг уламжлалт бэлчээрийн мал маллагаа болон хагас суурьшмал мал маллагааны аргын алийгч хэрэглэн мах, сүүний ашиг шимийг нэмэгдүүлэх бодлого чиглэл барьж тоо толгойг өсгөн үржүүлэх ажлыг цаашид мөрдөх</li> <li>Шиরуутэр ноост Байдраг үүлдрийн хонин сүргийг үндсэн сайжруулагчаар ашиглах</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн ямаан сүргийг хангай, тал, хээрийн сумдад Бөмбөгөр сумын Өлзийт голын улаан ямаа, говийн бүсийн сумдад Шинэжинст сумын Залаа Жинстийн цагаанаар эрчимжүүлэх</li> <li>Ноопуурын чанарыг сайжруулах зорилгоор Сүхбаатар аймгийн Баяндэлгэрийн улаан, Увс аймгийн Өлийн улаан, Говь-Алтай аймгийн Бугатын улаан, Ховдын Алтайн улаан зэрэг нутгийн шилдэг омгийн ухнаар сайжруулахыг аль ч бус нутгийн малчдад зөвшөөрч дэмжлэг үзүүлэх</li> <li>Адуун сүргийн тоо толгойг нэмэгдүүлж үүлдэр угсаа ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлийг сонгон үржлийн ажлыг явуулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Баянлиг суманд Ламын гэгээний “Сангарай улаан” тэмээг удам дагуулан цэврээ рнь үржүүлэх</li> <li>Өмнөговь аймгийн Галбын говийг улаан, Ханын хэцийн хүрэн шилмэл омгийн буурыг авч сайжруулагчаар ашиглах ажлыг бүх талаар тусалж дэмжих.</li> </ul>

<p><b>Зорилт 3.</b> Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх.</p>	2006- 2010	<ul style="list-style-type: none"> <li>Говь, тал хээрийн сумдын хүн амын сүү, махны хэрэгцээт шийдвэрлэхийн тулд ямаан сүргийн мах сүүний үүлдэр, Шведийн Тогенбург үүлдэрийн ухны гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэх туршилтын ажлыг хэрэгжүүлэх. Цаашид уг ажлын үр дүнгээр сүмдад сүүний үүлтрийн ямаагаар эрлийзжүүлах ажлыг зохион байгуулах</li> </ul>
	2011–2015	<ul style="list-style-type: none"> <li>Аймаг сумын төвийн хүн амын сүүний хэрэгцээг хангах чиглэлээр үүлдрийн үхрийг мах, сүүний хосолмол ашиг шимт Сичёв, Симменталь, Алатау, сүүний чиглэлийн Хар тарлан, Талын улаан зэрэг цэвэр үүлдрээр эрлийзжүүлэх ажлыг зохион байгуулж фермүүдийг аймгийн төвийн ойролцоо байгуулах</li> <li>Монгол үүлдрийн үхрийг төв суурингийн хүн амын махны хэрэгцээг хангах чиглэлээр эх орны “Сэлэнгэ”, Дорнод талын “Мухар улаан” үүлдэрүүдээр эрлийзжүүлэх ажлыг зохион байгуулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Бэлчээрийн даац сайтай Галуут, Эрдэнэцогт, Баяновоо, Өлзийт зэрэг сумын хонин сүргийг махны чиглэлээр цэвэр үүлдрийн түргэн өсөлттэй өндөр ашиг шимтэй хуцны гүн хөлдөөсөн үрээр эрлийзжүүлэх</li> <li>Аймаг, сумын төвийн ойроолцоо гахайн /фермерийн/ аж ахуйнуудыг бий болгон гахайн мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх</li> <li>Хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор тахиа галуу, туулай, зөгийн аж ахуй бий болгох санаачлагыг дэмжих туслах</li> <li>Малын удмын сантай болж мал хээлтүүлгийн ажлыг гүн хөлдөөсөн үрээр болон эвсэл үршилжүүлэн хээлтүүлдэг технологийг нэвтрүүлэх</li> <li>Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч фермүүдийг хагас суурьшсан мал маллаганы тогтолцоонд шилжүүлэх</li> </ul>
<p>4. Малчин өрх болон малыг эрсдлээс хамгаалах арга хэмжээг малчид төрийн хамтарсан үйл ажиллагааны үр дүнд авч хэрэгжүүлнэ.</p>	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Малчдад зах зээлийн эдийн засгийн сэтгэлгээ олгох сургалтыг системтэй зохион байгуулах</li> <li>Мал сүргийг индексжүүлсэн даатгалд хамруулах</li> <li>Бэлчээрийн эрсдлийн менежмент “Жей-Си-Эс” “Дэлхийн зөн”, “Говийн санаачлага” зэрэг гадаадын төслүүдэд хамрагдаж малжуулах жижиг үйлдвэрлэл эрхлэх хөрөнгийн эх үүсвэрийг ашиглах, хашаа, хороо барих, инженерийн хийцтэй уст цэг засварлах шинээр гаргах ажлыг үргэлжлүүлнэ</li> </ul>
	2011- 2015	<ul style="list-style-type: none"> <li>Малчдад урт хугацаатай бага хүүтэй зээл олгох санхүүгийн дэмжлэг үзүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Аймаг, сум дундын отрын бүс нутагтай болох, аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх</li> </ul>
<p>5. Мал амьтны халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар хүртээмжийг сайжруулна.</p>	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйлчилгээний хөлсийг төвлөрсэн болон орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлэх</li> <li>Сум бүр 2-оос доoshgүй стандартын шаардлага хангасан мал эмнэлэг, үрглийн аж ахуйн нэгжтэй болох</li> <li>Аймгийн мал эмнэлэг- ариун цэврийн лабораторийн материаллаг бааз, тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ, оношлогооны чадавхийг дээшлүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн чанартай гардаг оношлогдоогүй өвчнийг оношлох, эмчлэх шинжилгээ судалгааны ажлын арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Сумын мал эмнэлгүүдийн лабораторийн материаллаг бааз, багаж тоног төхөөрөмжийн хангамж, оношлогооны чадавхийг сайжруулах</li> </ul>

## 4.2. ХҮНСНИЙ ХАНГАМЖ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР

### **Үндэслэл:**

Хүн амын одоогийн хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний хүрэлцээ муу чанар нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна. Зөв зохистой хооллолтын дэглэм, хоолны бүтэц, жор норм, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, тэжээллэг хоолны ач холбогдолыг ойлгуулж хүмүүсийн зан үйлийн хэв маягыг өөрчлөх чиглэлээр сургалт сурталчилгаа муу хийгдэж байна. Тухайлбал: хоолны бүтцийн хувьд мах гурил будаа голлосон өөрөөр хэлбэл мах 17.6 хувь, гурил 41.0 хувь, будаа 10.0 хувь, төмс хүнсний ногоо 9.4 хувь, сүү сүүн бүтээгдэхүүн 19.8 хувь байгаа нь цаашид витаминлаг, илчлэг сайтай төмс хүнсний ногоо сүүн бүтээгдэхүүн өндөг, загас, жимс жимсгэнэ зэргийг хүнсний өргөн хэрэглэлийг шаардаж байна. Хүн амын хоол хүнсний хэрэглээ нь үнэ болон илчлэг чанар зэрэг үзүүлэлтийн хувьд иргэдийн амьдралын түвшингээр ялгаатай байна.

Иймд хүн амын хэрэглээний түвшинг дээшлүүлэх ухаалаг чанартай хэрэглээг төлөвшүүлэх шаардлагатай байна.

### **Стратегийн зорилт:**

1. Max, сүү, төмс хүнсний ногооны чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж хүнсний аюулгүй байдлыг хангана.
- 2.Хүн амыг зөв хооллолт, зохистой хэрэглээнд сургана.
- 3.Хүнсний аюулгүй байдалд тавих эрүүл ахуйн шаардлага, халдвартай судлалын хяналтыг тогтмолжуулна.

<b>Зорилт</b>	<b>Үе шат</b>	<b>Үйл ажиллагааны чиглэл</b>
1. Max, сүү, төмс хүнсний ногооны чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж хүнсний аюулгүй байдлыг хангана.	2006 - 2010	<ul style="list-style-type: none"> <li>• “Ногоон хувьсгал”, “Цагаан хувьсгал”, “Хүнсний хангамж аюулгүй байдал хоол тэжээл” үндэслний хөтөлбөрүүдийг бүтээлчээр хэрэгжүүлэх</li> <li>• -Мал нядлах газар маҳны стандартын зоорьтой болох</li> <li>• -Гахай тахианы аж ахуйг хөгжүүлэх</li> <li>• -Сум аймгийн төвд цагаан идээ, хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах</li> </ul>
	2011 - 2015	Хүн амын сүү сүүн бүтээгдэхүүний хэрэглээний 80 хүртэлх хувийг цөцгийн тосны 70 хувийг орон нутагтаа бэлтгэх Max, маҳан бүтээгдэхүүний борлуулалтын зохистой сүлжээ бүрдүүлэх Загас загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх Орон нутгийн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнээр хүн амаа бүрэн хангахын тулд төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийг 5 дахин, жимс жимсгэнийг нэмэгдүүлэх
	2016 – 2020	<ul style="list-style-type: none"> <li>○ Сүү, сүүн бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалаалт, борлуулалтын сүлжээ байгуулах</li> <li>○ Хоолны бүтцэд анхарч төмс хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, сүү сүүн бүтээгдэхүүн, өндөг, загас, гахай тахианы маҳны хувийг нэмэгдүүлж, малын мах, гурил, будаа, амьтны гаралтай тос, сахар чихрийн зүйлийн хувийг тодорхой хэмжээгээр бууруулах бодлого барьж ажиллах</li> </ul>
2. Хүн амыг зөв хооллолт, зохистой хэрэглээнд сургана.	2006- 2010	-Төмөр, „Д“ амин дэм бүхий бэлдмэл, иоджуулсан давс -Хүн амыг зөв хооллох, эрүүл хүнс хэрэглэж хэвшиг хорт зуршлаас өөрийгөө хамгаалахад чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааг өргөжүүлэх
	2011 - 2015	-Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл эхчүүд, ахмад настны болон тусгай хоол хэрэглэдэг хүн амын хоол тэжээлийг үйлдвэрлэх хадгалах түгээх үйлчилгээний сүлжээ бий болгох

	2016 - 2020	- хүн амын хоол хүнсний физиологийн нормыг нас хүйс ажил мэргэжил нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан тогтоож мөрдөх
3. Хүнсний аюулгүй байдалд тавих эрүүл ахуй халдвэр судлалын хяналтыг тогтмолжуулна.	2006 - 2010	-Хэрэглэгчдийг чанартай хүрэлцээтэй үндны усаар хангахад чиглэсэн бодлого явуулж усны зохицтой хэрэглээг төлөвшүүлэх. -Хүнсний хяналтын чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчинээр хангах, лабораториудыг бэхжүүлэх
	2011 - 2015	-Хүнсний аюулгүй байдлын хяналт эрсдэлийн шинжилгээний стандарт аргуудыг мөрдэж ажиллах, хүнсний хяналтын салбар хоорондын уялдаа холбоо хамтын ажиллагааг сайжруулах
	2016 - 2020	-Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний барагчны чанар, стандарт, эрүүл ахуйн үзүүлэлтийг өндөр нарийвчлалтай баталгаажуулдаг оновчтой тогтолцоог бий болгох.

#### 4.3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

##### Үндэслэл

Газар тариалангийн хувьд 1990 оноос өмнөх 13 суманд инженерийн хийцтэй 1344 га, 5 суманд энгийн услалтын системийн 460 орчим га, бугд 1800 га- талбайд төмс, хүнсний ногоо тэжээлийн ургамал тариалж 1300 тонн төмс, 890 орчим тонн хүнсний ногоо, 8000 гаруй тонн тэжээлийн ургамал хураан авч байв. Хангайн сумдад 8900 га- талбайд усалгаагүйгээр тэжээлийн ургамал тариалж байв. Гэтэл 2001 онд 593 өрх 78,2 га-д тариалж 284,1 тонн ургац, 2004 оны байдлаар 965 өрх 207,3 га-д тариалж 1413 тонн ургац, 2005 онд 1517 өрх, 28 аж ахуйн нэгж 316.4 га-д тариалж, 1984.4 тонн ургац хурааж байв.

Нэг га-ийн ургац үр тарианд 8.0 цн, төмсөнд 64.8 цн, хүнсний ногоонд 70.3 цн, тэжээлийн ургамалд 20.3 цн байгаа нь улсын дундажаас даруй 1,2 – 2,4 дахин бага байна.

2005 оны байдлаар аймгийн хүн амын хүнсний ногооны .....хувийг өөрсдөө хангаж байна. Малын тэжээлийн хэрэгцээний .....хувийг орон нутагт бэлтгэж байна.

##### а/ Газар тариалангийн үйлдвэрлэлийн давуу тал:

- “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай”, “Газрын тухай” хуулиуд, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого зэргийг батлан гаргаснаар тариалан эрхлэх эрх зүйн шинэ орчин буй болсон
- “Ногоон хувьсгал” хөтөлбөр амжилттай хэрэгжиж, аймгийн 2001-2004 оны газар тариалангийн үйлдвэрлэл өмнөх 4 жилийн дундажаас талбайн хэмжээ 1,5 дахин, хураан авсан ургац 36,4 хувь, тариалан эрхлэх өрхийн тоо 3,4 дахин ёсч, цаашид түүштэй хөгжих эхлэл тавигдаж, иргэдийн тариалан эрхлэх хүсэл, эрмэлзлэл нэмэгдсэн
- Аймгийн хөрс, цаг уурын нөхцөл хангай, говь, тал хээрийн 3 бүсийг хамардаг нь бүсийн онцлогтой тохирсон тариалан эрхлэхэд тохиромжтой
- Бүс бүрийн тариалан эрхлэх агротехнологи боловсролдон, мэргэжлийн агрономич, агротехникч хангалттай байгаа
- малчидын газар тариалан эрхлэх ажлын эхлэл эрчимжиж, төмс, хүнсний ногоо тариалах, нөөц бэлчээр, хадлангийн талбайг хашаалж сайжруулах ажилд ахиц гарсан

##### б/ Сул тал:

- Цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан усалгаагүйгээр тариалан эрхлэх боломж муутай
- Тариалан эрхлэх уламжлал багатайн дээр ач холбогдлыг нийтээр сайтар ойлгохгүй байгаа
- Тариаланч, малчдын боловсролын түвшин доогур, насны хувьд залуужснаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн явуулах мэдлэг, дадлага хангалтгүй
- Шинэ дэвшилтэй техник, технологийг эзэмших, нэвтрүүлэх явдал удаашралтайгаас үйлдвэрлэлийн эрчимжилт хангалтгүй
- 90-ээд оноос өмнө ажиллаж байсан услалтын системүүдийг бүрэн устгаснаас ихээхэн хэмжээний газар орхигдсон атаршиж эвдрэл элэгдэлд илүүтэй орж цөлжих үйл явц эрчимжсэн.

Хөтөлбөрийн зорилго:

Нэгэнт хүрсэн түвшинг бууруулахгүйгээр урд нь олсон ололтоо бататган, “Нэг баг- нэг шилдэг бүтээгдэхүүн” хөдөлгөөний хүрээнд орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан, иргэдийн санаачилга, идэвхийг өрнүүлэн, аймгийн хөрс, цаг уур, бүс нутгийн онцлог/бахархал/-т тохирсон газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөжүүлэн эрчимтэй эрхлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулж, экологийн цэвэр, чанар сайтай хүнсний бүтээгдэхүүнээр аймгийн хэрэгцээг бүрэн хангаж, импортын бүтээгдэхүүний нэр төрлийг бууруулна.

## Стратегийн зорилт

**Стратегийн зорилт:** 1. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, дадлагыг дээшлүүлэх, мэргэшил эзэмшүүлэх сургалтын системийг боловсронгуй болгон төлөвшүүлж, чадварлаг мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчид бэлтгэнэ

**Стратегийн зорилт:** 2. Аймгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон эрчимжсэн газар тариаланг эрхлэх замаар газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ

**Стратегийн зорилт:** 3. Хамгаалагдсан хөрсний тариалангийн аргыг өргөн эзэмшиж, тарималын нэр төрлийг олшуулж, ургацаа нэмэгдүүлж, хүнсэндээ шинэ ногоо хэрэглэх хугацааг уртасгана

**Стратегийн зорилт:** 4. Өрх бүр худаг, цас, борооны гэх мэт усны эх булагийг өргөн ашиглан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах ажлыг өргөжүүлэх, усыг хэмнэлттэй зарцуулах технологийг эзэмшинэ

**Стратегийн зорилт:** 5. Техникийн хангамжийг сайжруулан газар тариалангийн ажлын механикуулалтын түвшинг нэмэгдүүлнэ

**Стратегийн зорилт:** 6. Ургац болон ургамал хамгааллын арга хэмжээг сайжруулна:

**Стратегийн зорилт:** 7. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс хамгаалах арга ажиллагааг сайжруулна

**Стратегийн зорилт:** 8. Бэлчээр сайжруулах таримал бэлчээрийн хэмжээг нэмэгдүүлэх эхихэр мал аж ахуйн тэжээлийн баазыг бэхжүүлнэ.

<b>Зорилтууд</b>	<b>уе шат</b>	<b>Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл</b>
1. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, дадлагыг дээшлүүлэх, мэргэшил эзэмшүүлэх сургалтын системийг боловсронгуй болгон төлөвшүүлж, чадварлаг мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчид бэлтгэнэ	2006-2010  2011- 2015  2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг олгох, мэдээлэл түгээх, дамжуулах, шинэ технологи эзэмшүүлэх, зуучлах үүрэг бүхий хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээг төрийн байгууллагын эрх зүйн орчинд байгуулах</li> <li>Иргэд, тариалан эрхлэгчдийг тарьж ургуулах, хамгаалах, хадгалах, боловсруулах, хэрэглэх арга технологид сургах агропаркуудыг төрийн болон хувийн хэвшлийг түшиглүүлэн байгуулж ажиллуулах</li> <li>Төрийн болон өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн судалгаа- сургалтын төвүүдийг байгуулах</li> </ul>
2. Аймгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон эрчимжсэн газар тариаланг эрхлэх замаар газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	2006-2010  2011-2015  2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, нэг га-аас авах ургацыг нэмэгдүүлэх <ul style="list-style-type: none"> <li>- 1065 га-д тариалж, 10800 тонн төмс, 1900 тонн хүнсний ногоо, жимс жимсгэнэ хураах, га-ийн ургац 120 центнерт хүргэх <ul style="list-style-type: none"> <li>- 1500 га-д тариалж, 14000 тонн төмс, 7000 тонн хүнсний ногоо, жимс жимсгэнэ хураах Га-ийн ургац 140 центнерт хүргэх</li> </ul> </li> </ul> </li> <li>ШУА-ны салбар хүрээлэнгүүдтэй хамтран Богд сумыг түшиглэн чухал, нэн ховор ургамлыг тарималжуулах туршилт-судалгааны төвийг ажиллуулах</li> <li>Баацагаан, Богд, Бөмбөгөр, Баянговь зэрэг сумдад чихэр өвс, лидэр, нохойн хошуу, гүргэм гэх мэтийн чухал ургамлуудыг тарималжуулах</li> <li>Баянхонгор, Бууцагаан, Баянговь сумдад нутагшсан үр үйлдвэрлэх, жимс, жимсгэний тарьц, суулгац үржүүлэх, эх ургамлын цэцэрлэг, талбай байгуулах замаар иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээг бүрэн хангах</li> </ul>
	2016-2020	Эмийн болон хүнсний ургамалын анхан шатанд боловсруулах үйлвэрүүдийг байгуулж, импортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх

3. Хамгаалагдсан хөрсний тариаланг өргөн эзэмшиж, тарималын нэр төрлийг олшуулж, ургацаа нэмэгдүүлж, хүнсэндээ шинэ ногоо хэрэглэх хугацааг уртасгана	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Халуун рашаан, дулааны найдвартай эх үүсвэртэй газруудад жилийн турш ажиллах хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх</li> <li>Бууцай, яншуй мэтийн хурдан болцтой навчт ногоо, вандуй, шар буурцагийн ургал зэргийг хүнсэнд хэрэглэх, хэмх, тооль, гүзээлзэнэ, амтат журж, хүлэмжинд угуулдаг арга туршлагыг судлан дэлгэрүүлэх</li> <li>Төмс, хэмх, тарvas, сонгино болон зарим төрлийн тарималын үр шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх</li> </ul>
	2011 -2015	<ul style="list-style-type: none"> <li>Төмс, хүнсний ногооны талбайг нийлэг хальсаар бүтээх замаар чийгийн ууршилтыг бууруулах, хог ургамлын ургалтыг хязгаарлах, дулаан хуримтлуулан хүйтнээс хамгаалах, ургац нэмэгдүүлэх арга технологийг эзэмшүүлэх, дэлгэрүүлэх</li> <li>Хүлэмж, нүхэн хонгилын дотроо утсан бэхэлгээтэй, салхи, хүйтэнд тэсвэртэй, 5-10 жилийн эдэлгээтэй, бат, бэх нийлэг хальсны олдоцыг нэмэгдүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Энгийн хийцтэй хүлэмж, хонгил/туннель/-ийг үйлдвэрлэх, импортлох, нийлэг хальсан бүрхүүл, хучлагын материалыг импортлох</li> <li>Хадгаламжийн аж ахуй бүхий газар тариалангийн бүтээгдэхүүний бөөний худалдааны дундын хоршооллыг байгуулж бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлтийг арилгах</li> </ul>
4. Өрх бүр худаг, цас, борооны мэт усны эх булагийг өргөн ашиглан темс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах ажлыг өргөжүүлэх, усыг хэмнэлттэй зарцуулах технологийг эзэмшинэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Ашиглалтгүй байгаа услалтын системүүдийн өмчлөлийг шийдвэрлэн дэс дараатайгаар засварлаж бүрэн ашиглах</li> <li>Тариалан эрхлэдэг иргэд, өрх, фермер, аж ахуйн нэгж бурийг төвлөрсөн усан хангамж, гүний болон бетон хашлагатай, энгийн худаг, усан сан, услалты системийн аль боломжтойг нь ашигладаг болгох</li> <li>Өвөл, хаврын улиралд жимс, ногооны талбайд хунгар, цас тогтоох, байшин барилгын дээврийн усыг хуримтлуулж усалгаанд хэрэглэх аргыг өргөн ашиглах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Жимс, ногооны талбай, ялангуяа хамгаалагдсан хөрсний тариаланд дуслын болон нэвчих усалгаа, мананжуулах, бороожуулах усалгаа зэрэг ус хэмнэх сүүлийн үеийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх</li> </ul>
	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Зардал хэмнэх, хөрсний элэгдэл, эвдрэлийн хэмжээг багасгах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын мал/ шар, адuu, тэмээ, илжиг гэх мэт/- ыг тариалангийн ажилд ашиглан бага механизмуулалтыг өргөн нэвтрүүлэх</li> <li>Тариалангийн ажлын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангамжийг сайжруулахад лизингийн үйлчилгээг нэвтрүүлэх</li> </ul>
5. Техникийн хангамжийг сайжруулан газар тариалангийн ажлын механизмуулалтын түвшинг нэмэгдүүлнэ.	2011-2015	Өрхийн болон фермерийн тариаланд ашиглах гар багажийг импортлох, дотооддоо үйлдвэрлэх, засварлах аж ахуйн нэгжийг байгуулах, тариаланч ногоочдыг хангах
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Өрхийн болон жижиг аж ахуйн хэрэгцээнд тохирсон бага хүчин чадлын трактор, хөдөө аж ахуйн чиргүүл, дүүжин машин, бороожуулагчийг импортлох замаар хангах арга хэмжээ авах</li> </ul>
	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Тариалангийн хөнөөлт шавьж, хортон, өвчин, хог ургамалтай тэмцэх зориулалттай бодисын олдоц, хангалтыг сайжруулах</li> </ul>
6. Ургац болон ургамал хамгааллын арга хэмжээг сайжруулна.	2011-2016	<ul style="list-style-type: none"> <li>Лооль, чинжүү, тамхины болон бусад ургамлын иш, навч зэргийг хандалж уусмал бэлтгэн хөнөөлт шавьж, ургамлын өвчин, хортонтой тэмцэх, экологид хор хөнөөлгүй, энгийн арга ажиллагаанд иргэдийг сургаж дадлагажуулах</li> </ul>

	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Жимс, тариалангийн талбайт мал, гадны халдлагаас хамгаалах зорилгоор төрөл бүрийн хийц, загварын удаан эдэлгээтэй, хямд төсөр хашааны үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалтанд дэмжлэг үзүүлж, хангах</li> </ul>
7. Хөрсний үргжил шимийг нэмэгдүүлэх, хөрс хамгаалах арга ажиллагааг сайжруулна.	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Бууц, аргал, хомоол, уртэс, сангас зэрэг органик бодисыг бордоо болгон ашиглах арга ажиллагаанд тариаланч, ногоочдыг сургаж дадлагажуулах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Дотоодод үйлдвэрлэж ашиглаж байгаа төрөл бүрийн биобордоо, багсармал болон гумин, цеолитийн бордооны үйлдвэрлэл, хангалт, хэрэглээг нэмэгдүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн олдоц сайтай түүхий эд/бууц, шувууны сангас, цеолит, шохой/-ийг түшиглүүлэн шим бордооны жижиг үйлдвэр байгуулах</li> </ul>
8. Мал аж ахуйн тэжээлийн баазыг бэхжүүлэх, бэлчээр сайжруулах таримал бэлчээрийн хэмжээг нэмэгдүүлнэ	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>Тариаланд ашиглагдаж байгаад орхигдсон усалгаатай 210 га, усалгаагүй 1000 га талбайд хадлангийн болон таримал бэлчээрийн зориулалтаар олон наст ургамал, наранцэцэг, эрдэнэшиш зэрэг тэжээлийн ургамал тариалах</li> <li>Усны эх булгигүй түшиглүүлэн талбай хашаалах замаар бэлтгэх хадлангийн хэмжээг нэмэгдүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Атаршсан, орхигдсон тариалангийн талбайг иргэн, аж ахуйн нэгжид өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах</li> </ul>
	2015-2020	<ul style="list-style-type: none"> <li>Услалтын систем, усны эх булгигүй түшиглүүлэн тэжээлийн нэг болон олон наст ургамал тариалах, таримал бэлчээр бий болгох ажлыг өргөжүүлэх, нуур, булаг шандны орчмын ургамлын нөөцийг ашиглах замаар бага оврын тэжээлийн үйлдвэрүүдийг байгуулах</li> </ul>

#### 4 . 4 . Б А Й Г А Л Ь      О Р Ч И Н      Г А З Р Ы Н      Х А Р И Л Ц А А Н Ы      Х є Г Ж И Л

**Үндэслэл:**

Тус аймаг нь 11597780 га нутагтай хангай,.govь хээр хослосон байгалийн асар их баялагтай. Газрын нэгдмэл сангийн хувьд ХАА-н газар 8982.07 мянган га, хот тосгон бусад суурин 16.9 мянган га, ойн сан бүхий газар 490, мянган га, усан сан бүхий газар 51.0 мянган га, зам шугам сүлжээ бүхий газар 5.1 мянган га нутаг дэвсгэрийг хамарч байдаг.

Баянхонгор аймгийн Хар ус, Шар ус, Заг, Байдраг, Цагаан туроо, Харгана, Сүмбэр, Шаргалжуут, Түйн голууд нь бүх жижиг цутгадаг голуудтайгаа дэлхийн цэвэр усны хагалбар болсон Хангайн нуруунаас эх авдаг ба төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд хамаардаг.

Манай аймгийн хувьд гадаргын усны түвшинг хэмжих зорилгоор Түйн гол дагуу Баянхонгор, Богд сум орчимд 2 харуул, Байдраг гол дагуу, Жаргалант, Бууцагаан орчмын 2 харуул, Заг, Цагаан Туруут, Шаргалжуут, Шар ус тус бүр 1 харуул, Орог, Гурванбулаг сумын Хөх нуур, Бөөнцагаан нуур орчим тус бүр 1 харуул ажиллаж байна. Эдгээрийн материалаас үзэхэд гадаргын ус суулийн 40 жилийн өмнөөс багасаж эхэлсэн байна.

Аймгийн нийт нутгийг хамруулан 2003 оны суулийн байдлаар гадаргын усны тооллого хийхэд, нэгдсэн дунгээр 299 гол горхи, 104 нуур, 837 булаг шанд байгаагаас, 61 гол горхи, 38 нуур, 55 булаг шанд ширгэсэн байна гэсэн дүн гарч байна. Аймагт Шаргалжуут, Үхэг, Өргөт зэрэг эмчилгээний зориулалттай 22 рашаан байдаг бөгөөд эдгээрт хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс тогтоогоогүй ашиглаж байна.

Баянхонгор аймгийн хойд хэсгээр 12,6 мянган га шинэсэн, өмнөт хэсгээр 477,8 мянган га заган ой болон түүний бүрэлдэхүүнд орох бусад бүт, сөөг байна. Ойн нийт талбай 490,4 мянган га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 4,2 хувийг эзэлдэг бөгөөд үүнээс заган ой 97,4 хувийг, шинэсэн ой 2,6 хувийг эзэлж байна.

Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 19.5 хувь буюу 2265,5 мянган га газар улсын тусгай хэрэгцээний газарт хамрагддаг бөгөөд үүнээс дархан цаазтай газар 1361,5 мянган га, байгалийн цогцолборт газар 810,7 мянган га, хилийн зуравс газар 74,5 мянган га-г эзэлж байна. Аймгийн тусгай хэрэгцээний газар 1773,3 га байгаагаас хайгуулын зориулалтаар 345,9 мянган га газрыг чөлөөлөөд байна.

Одоогийн байдлаар тус аймагт Галуут, Заг, Баян-Овоо, Гурванбулаг, Бөмбөгөр, Баян-Өндөр, Жаргалант, Шинэжинст, Бууцагаан, Өлзийт зэрэг сумдын уурхайн эдэлбэрийн 66 орд газарт 46 аж ахуйн нэгж, байгууллага 14481 га талбайг ашигт малтмал олборлох зориулалтаар лиценз авсан байна. Үүнээс алт олборлолтын 45 аж ахуйн нэгж 65 орд газарт, нүүрс олборлолтын 1 аж ахуйн нэгж 1 орд газарт лиценз аваад байна. Уул уурхайн компаниуд 2003 онд 164.4 га-д хөрс хуулалт хийж 46.9 га нэхэн сэргээлт хийхээр төлөвлөснөөс 21.9 га-д техникийн нэхэн сэргээлтийг хийсэн байна. 2004 онд 574.5 га-д хөрс хуулж 36.32 га-д нэхэн сэргээлт хийхээр төлөвлөснөөс 66.03 га нэхэн сэргээлт хийсэн 2005 онд 172.57 га-д нэхэн сэргээлт хийхээр төлөвлөж байна..

Байгалийн дагалт баялаг болох жимс, сонгино, эмийн ховор ургамлыг түүхдээ үндэс мөчрийг ухах, таслах зэрэг зохисгүй үйлдлээр ашиглах байгаад орон нутгийн засаг захиргааны болон ард иргэдийн хяналт орхигдож, дахин нөхөн сэргээгдэхгүйд хүрээд байна. Цаашид жимс, сонгино, эмийн ургамлын тархац, нөөцийг тогтоох судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэн тархац бүхий нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах талаар төлөвлөж байна. Ер нь аймгийн хэмжээн дэхь ургамлан нэмрэгийн нөөц, байршилийг тогтоох зайлшгүй шаардлагатай байна.

Аймгийн хэмжээгээр агаарын болон орчны бохирдолыг үүсгэгч эх үүсвэр 26885 байгаа бөгөөд үүнээс уурын зуух 101, тээврийн хэрэгсэл 5347, шатахуун түгээх станц 80, айл өрхийн жижиг зуух 21357 байна. Хот суурин газрын агаар орчны бохирдолыг багасгахын тулд эрчим хүчиний болон үйлдвэрийн салбарт экологи эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нар, салхи, ус, байгалийн хийг ашиглах, бохирдуулагч эх үүсвэрүүдийг шүүлтуүрийн төхөөрөмжтэй болгох, шаталт сайтай тулш бага хэрэглэдэг утаа бага гаргадаг зуух, хийн зуухыг өргөн хэрэглэх, хог хаягдлыг ялгах, хогийн нэгдсэн цэгийг цэгцлэх шаардлагатай.

Аймгийн хэмжээнд хогийн цэг 89,5 га талбайг эзэлдэг. Өнөөдрийн байдааар хог хаягдлыг боловсруулах нөхцөл бүрдээгүй, хатуу хог хаягдлыг хот суурин газрын орчинд ил задгай хаяж байгаа нь байгаль орчныг бохирдуулах эх үүсвэр болдог. Баянхонгор сумын иргэд хог хаягдалаа хогийн цэгт хүргэхгүй асгаж байгаагаас хаяагаа тэлж, хоттойгоо нийлж эргэн тойрон шинээр хогийн цэг бий боллоо.

### Стратегийн зорилт.

**Стратегийн зорилт. 1: Аймгийн ногоон бүсийн талбайг ихэсгэж “Ногоон хэрэм “ хөтөлбөрийг хэрэгжүүлж, төв суурин газруудад мод тарьж ургуулна.**

**Стратегийн зорилт. 2: Газрын хэвлэлийн ашиглалтыг сайжруулж алт, зэс, молебдин болон бусад ашигт малтмалын судалгаа шинжилгээний ажлуудыг хийж, тэдгээрийн нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэх**

**Стратегийн зорилт. 3: Гадаргын болон гүний усны эх ундарга, гүний худгуудыг хамгаалах, засварлан сайжруулах, уст цэгүүдийг цэнгэгжүүлэх**

**Стратегийн зорилт. 4: Байгалийн ургамлан нэмрэгийг хамгаалах, түүний ашиглалтыг сайжруулах судалгаа шинжилгээ хийлгэх**

**Стратегийн зорилт. 5: Аи амьтныг хамгаалах, судалгаа шинжилгээ хийх, нөхөн үржүүлэх хамгаалтад авах**

**Стратегийн зорилт. 6: Орчны бохирдолыг бууруулах, хог хаягдлыг цэгцлэх**

**Стратегийн зорилт. 7: Газрын мэдээллийн сан**

**Стратегийн зорилт. 8: Газрын шинэтгэлийг эрчимжүүлж, газрын менежментийг боловсронгуй болгох**

**Стратегийн зорилт. 9 Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, хамгаалах**

**Стратегийн зорилт. 10: Төв суурин газрын газар ашиглалтыг сайжруулах**

**Стратегийн зорилт. 11 Тариалан, хадлан, бэлчээрийг зүй зохицтой ашиглах, хамгаалах үржил шимийг нь бууруулахгүй байх**

**Стратегийн зорилт. 12: Газрыг хамгаалах, нөхөн сэргээх**

**Стратегийн зорилт. 13: Цаг уурын шинжилгээний ажлыг өргөтгөх**

**Стратегийн зорилт. 14 Цаг уурын техник технологийн шинэчлэл хийх**

**Стратегийн зорилт. 15: Цаг уурын мэдээллийн чанарыг сайжруулах**

**Стратегийн зорилт. 16: Цаг уурын өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах.**

Зорилт	Үе шат	Үйл ажиллагааны чиглэл
Аймгийн ногоон бүсийн талбайг ихэсгэж “Ногоон хэрэм “ хөтөлбөрийг хэрэгжүүлж, төв суурин газруудад мод тарьж ургуулна.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн хэмжээнд дасан зохицож ургах чадвартай тарьц, суулгац 100 мянган ширхэгийг ургуулах</li> <li>• Заган болон шинэсэн ойг нутгийн иргэдэд дундын хэлбэрээр эзэмшүүлэх ажиллагааг жигдруүлэх</li> <li>• Ногоон хэрэм хөтөлбөрийг үргэлжлүүлэх</li> <li>• Аймгийн ойн зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх</li> <li>• Орон нутагт зохицон дассан мод үржүүлгийн газрыг ой бүхий сумдад байгуулах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>• Түйн голын бургасыг нөхөн сэргээх ажиллагааг төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах</li> <li>• Төв суурин газруудад мод тарьж ургуулах, цэцэрлэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>• “Ойжуулалт-20” хөтөлбөрийг хэрэгжүүлж дуусах</li> </ul>

<b>Газрын хэвлийн баялагийн нөөцийг судалж, эдийн засгийн үндсэн үнэлгээ тогтоох, зохистой ашиглана.</b>	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Урьд онуудад болон тухайн жилд эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэх</li> <li>Нөөц нь тогтоогдоогүй талбайн нөөцийг тогтоолгон ашиглаулах</li> <li>Нөхөн сэргээлт болон хайгуул ашиглалтын үйл ажиллагаанд байнга хяналт тавьж байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх</li> <li>Гар аргаар алт олборлогчдыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Байдраг, Түйн голын ай сав газарт ашиглалт явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоож нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэж жимсний мод тарих ажлыг төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх</li> <li>Уул уурхайн салбарт шинэ техник технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжиж байгальд учруулах хохирлыг багасгах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Алт, нүүрс болон бусад ашигт малтмалын нөөцийг аж ахуйн нэгжийн хайгуулыг судалгааг явуулан нөөц тогтоох</li> <li>Илэрсэн нөөцүүдийг ашиглан үйлдвэрлэл эрхлэх боломжийг бүрдүүлж гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжин оруулах</li> </ul>
<b>Гадаргын болон гүний усны эх үндарга, гүний худгуудыг хамгаалах, засварлан сайжруулах, уст цэгүүдийг цэнгэгжүүлэнэ.</b>	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Хатуулаг ихтэй уст цэгүүдэд цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах</li> <li>Томоохон голуудын ай савын зөвлөл байгуулах, булаг шандын эх үндаргыг хашиж хамгаалах</li> <li>Рашаануудад шинжилгээ хийж, хамгаалалтын дэглэм тогтоох</li> <li>Гүний худгуудыг шинээр гаргах, эвдэрсэн уст цэг худгуудыг засварлах тоог нэмэгдүүлэх</li> <li>Томоохон голуудын ай сав газрын зөвлөл байгуулах.</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Усны эрдэсжилтийн хэмжээг 60 хувь бууруулах.</li> <li>Гадаргын усны урсацыг тохируулах, гадаргын усны ашиглалтыг 50 хувь хүртэл нэмэгдүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн хэмжээнд ус ашиглагчдын 80 хувь нь цэвэр усаар хангдах</li> </ul>
<b>Байгалийн ургамлан нэмрэгийн нөөцийг судалж, эдийн засгийн үнэлгээ тогтоох, тэдгээрийн экологийн аюулгүй байдлыг хангаж, зохистой ашиглана.</b>	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн ургамлан нэмрэгийн байршил, нөөцийг судалж эдийн засгийн үнэлгээ тогтоох</li> <li>Ховор, нэн ховор ургамлын нөөцийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож хамгаалалтанд авах арга хэмжээ авах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Эмийн болон ашигт тархац нөөцийн ургамлуудын судалгаа хийж гадаад улс орон болон дотоодын хэрэгцээг хангах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Ард иргэдэд нэн ховор, ховор ургамлуудын талаар мэдээлэл өгөх, түүний ач холбогдлын талаар сурталчилах чихэр ёвс, лидер болон бусад ашигт ургамлыг тарьж ургуулах</li> <li>Нөөцийн дагуу ашиглалт хамгаалалтыг сайжруулах</li> </ul>
<b>Ан амьтныг хамгаалах, судалгаа шинжилгээ хийх, нөхөн үржүүлэх хамгаалтад авна.</b>	2005-2015	<ul style="list-style-type: none"> <li>Ховордсон амьтдын тооллогыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулан, хамгаалах менежментийг боловсронгуй болгох, орон нутгийн ард иргэдийн оролцоог дээшлүүлэх</li> </ul>
<b>Орчны бохирдолыг бууруулах, хог хаягдлыг цэгцлэнэ.</b>	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Хийн түлш хэрэглэх замаар орчны болон агаарын бохирдолыг багасгах</li> <li>Хог хаягдалын менежментийг боловсронгуй болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх</li> </ul>
	2011-2016	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдалыг ялгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулах</li> <li>Удаан задардаг химиийн бохирдуулагчийг төвлөрсөн цэгт төвлөрүүлж устгах ажлыг зохион байгуулах</li> </ul>

<b>Газрын мэдээллийн сан</b>	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Газрын харилцааны чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлэхэд зайлшгүй шаардагдах программ хангамж, техник тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх</li> <li>Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо бүртгэлийг нэгтгэн гаргах, шилжилт хөдөлгөөнийг цаг тухай бүрд нь хийх</li> <li>Зурган мэдээллийг сум бүрээр гарган тоон мэдээлэлтэй холбох</li> <li>Мэдээллийн сангийн бодит байдлыг дээшлүүлж орчин үеийн техник технологоор мэргэжлийн өндөр түвшинд боловсруулсан үнэн зөв баталгаатай мэдээллийн сангаар үйлчлэх</li> <li>Эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэл түүнтэй холбоотой бусад эрхийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, архивлах, олон нийтэд улсын бүртгэлийн талаарх хууль тогтоомжийг сурталчилах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Анхан шатны мэдээллийн санг ашиглан аймгийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох</li> <li>Орчин үеийн өндөр нарийвчлалтай багаж тоног төхөөрөмж ашиглан шинээр үүсэх газар эзэмшигчдийг мэдээллийн санд нэмэн оруулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Аймаг орон нутгийн газрын мэдээллийн санг улсын мэдээллийн сан сүлжээтэй холбох</li> </ul>
<b>Газрын шинэтгэлийг эрчимжүүлж, газрын менежментийг боловсронгуй болгоно.</b>	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах</li> <li>Монгол улсын иргэдийн гэр бүлийн хэрэгцээнд үнэгүйгээр эзэмшүүлэх газар болон төрийн байгууллагын шууд хэрэгцээнд зайлшгүй эзэмшүүлэхээс бусад газрыг зөвхөн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар олгох</li> <li>Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд өмчлүүлэх боломжтой газрыг иргэдэд хүсэлтийнх нь дагуу өмчлүүлэх ажлыг зохион байгуулах</li> <li>Урьд онуудад төлөгдөөгүй болон газрын төлбөрөөс ямар нэгэн байдлаар зайлсхийсэн зөрчлийг арилган, төлбөрийн өрийг барагдуулах</li> <li>Нийгэм эдийн засгийн нөхцлийг харгалзан үзэж, төлбөр ноогдуулах бүсчлэлийг шинэчлэн тогтоон, эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа газрын төлбөрийг нягтлан шалгаж эрх зүйн хувьд баталгаажуулах</li> <li>Орчин үеийн нарийвчлал бүхий гео багаж, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Эзэмшил ашиглалт, өмчлөлд байгаа газарт төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгүүлэх хяналт тавих.</li> <li>Баруун болон төвийн бусуудийн нутгууд суурин GPS-ийн сүлжээнд холбогдох</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тодотгох, өөрчлөлт оруулах талаар гаргасан саналыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх</li> </ul>
<b>Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, хамгаална.</b>	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд хамруулан авсан газарт он дарааллын бичиг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх</li> <li>Өвөрмөц тогтоц, ховор ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүхийн дурсгалт газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авч нийт нутаг дэвсгэрийн ... хувийг хамруулах</li> <li>Ховор ховордсон ургамал, амьтан бүхий Их бодг орчмын газрыг Улсын тусгай хамгаалалтанд авах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн болон түүх соёлын дурсгалт газар, үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах зорилгоор Галуутын хавцал, Цагаан агуйг улсын тусгай хамгаалалтанд авах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн өвөрмөц тогтоц бүхий Шаргалжуутын рашаан сувилалыг Улсын тусгай хамгаалалтанд авах</li> </ul>
<b>Төв суурин газрын газар ашиглалтыг сайжируулна.</b>	ы2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Хотыг хөгжүүлэх чиг хандлагыг тодорхойлсон төлөвлөгөө боловсруулан суурин газарт эзэмшил газрыг олгоходо газар зүйн онцлог, нийгэм эдийн засгийн ач холбогдол, ариун цэвэр эрүүл ахуйн нөхцлийг харгалзан төлөвлөгөөтэйгээр олгох</li> <li>Инженерийн байгууламжийн бус, шугам сүлжээний хамгаалалтын бусэд байршилтай айлуудыг шилжүүлэн байршуулах</li> <li>Төлөвлөгөөний дагуу тогтворт сууршилтай байршсан гэр хорооллын айл өрхүүдэд хуулийн дагуу газрыг өмчлүүлэх</li> </ul>

	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Газрын биржийг байгуулан ажиллах</li> <li>Зайлшгүй шаардлагатай тохиолдолд шинээр гэр хорооллыг байршуулах, одоо байршиж байгаа гэр хорооллын өнгө үзэмжийг сайжируулах тэгшлэх зохион байгуулалттайгаар хаягжуулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Суурьшлийн бус газрыг тодорхой чиг үүрэг бүхий дэд бус буюу функционоль бусуудэд хувиарилах замаар ашиглах</li> <li>Орчин үеийн тохилог хот бий болгох</li> </ul>
Тариалан, хадлан, бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах үржил шимийг нь бууруулахгүй байна.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржaa, отрын нөөц нутаг гэсэн ерөнийхүү хуваарийг тусган зүй зохистой ашиглуулах хамгаалах.</li> <li>Мал, амьтан бэлчээхэд тусгайлан зориулснаас бусад тохиолдолд тариалангийн талбайд үр суулгаснаас ургац хурааж дуусах хүртэл хугацаанд мал, амьтан бэлчээхийг хориглох</li> <li>Тариалангийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах замаар эрхийг баталгаажуулан гэрээг жил бүр дүгнэх, хүсэлтийн дагуу тариалангийн талбайг үнээр нь худалдан өмчлүүлэх</li> <li>Хадлангийн талбайд газар зохион байгуулалтын арга хэмжээ авч, бэлчээрийн зохих ургацтай хэсгийг хадлангийн талбай болгон хадлан авах бололцоотой талбайг жил бүр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Зуслан, намаржaa болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Өвөлжөө, хаваржааны орчмын бэлчээрийг талхлагдааас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бус нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан гэрээнд дагуу эзэмшүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа иргэн аж ахуйн нэгж байгууллагад бэлчээрийг эзэмшүүлэх</li> </ul>
Газрыг хамгаалах, нөхөн сэргээнэ.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Газрыг хамгаалах, нөхөн сэргээх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх</li> <li>Газрыг хамгаалах нөхөн сэргээх сан байгуулан газрын төлбөрийн 30-аас доошгүй хувийг төвлөрүүлэн газар хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах</li> <li>Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгох</li> <li>Эрэл хайгуул хийх, барьж байгуулах, ашигт малтмал олборлох явцад эвдэрсэн болон буруу ашиглалтаас болж эвдэрсэн газрыг гэм буруутай этгээдээр төлүүлэн нөхөн сэргээх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр газрын төлөв байдлаа алдах өөрчлөгдөх, үржил шим болон бусад ашигтай чанар нь буурах газар ашиглах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага зөрчигдсөн тохиолдолд газрыг төрийн мэдэлд эргүүлэн шилжүүлэх</li> <li>Тариалангийн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа этгээд хөрсийг хамгаалах, түүний үржил шимийг бууруулахгүй байх арга хэмжээ байнга авч газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгүүлэх хяналт тавих.</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>Хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурсас тарих зэргээр өөрийн хүч, хөрөнгөөр сайжруулалт хийж, ургацыг нь тогтвортой дээшлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх</li> </ul>
Цаг уурын шинжилгээний ажлыг өргөтгөнө.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>Агаар чанарын харуулыг агаар, хөрс, усны бохирдолын лаборатори болгон өргөтгөх</li> <li>Цаг уур ус судлалын өртөө харуулын хөтөлбөрийг гүнзгийрүүлэн Байгаль орчинд гарч байгаа хувирал өөрчлөлтийг судлан тогтооход чиглэсэн ажлыг өргөтгөх</li> </ul>
	2005-2015	<ul style="list-style-type: none"> <li>ХАА-н харуулын хөтөлбөрийг өргөтгэж цаг уурын өртөө болгох эхлэлийг тавих</li> </ul>
	2008-2016	<ul style="list-style-type: none"> <li>Ус судлалын харуулыг З-аар нэмэгдүүлж, гүний усны ажиглалтын сүлжээг бий болгох</li> </ul>
	2012-2016	<ul style="list-style-type: none"> <li>Эхийн голын цаг уурын өртөөний барилгыг шинэчлэн тоноглох</li> </ul>

Цаг уурын техник технологийн шинэчлэл хийнэ.	2008-2010	<ul style="list-style-type: none"> <li>Цаг уурын салбаруудыг нэгдсэн холбооны сүлжээтэй болгох</li> </ul>
	2010-2015	<ul style="list-style-type: none"> <li>Цаг уурын өртөөнүүдэд автомат цаг уурын станц тавих</li> </ul>
	2005-2020	<ul style="list-style-type: none"> <li>Техник хангамжийг шинэчлэх</li> </ul>
Цаг уурын мэдээллийн чанарыг сайжруулана.	2005-2020	<ul style="list-style-type: none"> <li>Ус цаг уурын орчны шинжилгээний бүх мэдээллийг цахим хадгалуурт шилжүүлэх</li> </ul>
	2008	<ul style="list-style-type: none"> <li>Баянхонгор аймгийн уур амьсгалын 2-р лавлах ботийг зохиож хэвлүүлэх</li> </ul>
	2006	<ul style="list-style-type: none"> <li>Цаг уурын урьдчилсан мэдээллийг пунктээр зохиож хэрэглэгчдэд хүргэх, АА-н нэгж компаниудад захиалгат мэдээгээр үйлчлэх</li> </ul>
Цаг уурын өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургана.	2006-2020	<ul style="list-style-type: none"> <li>Салбарыг мэргэжлийн боловсон хүчинээр хангах, давтан сургалтанд хамруулах, боловсон хүчинийг тогтвортой ажиллуулах урамшууллын механизмыг бүрдүүлэх</li> </ul>
	2006-2020	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын мэргэжлийн боловсон хүчиний чадавхи, мэргэжлийн түвшинг дэлхийн цаг уурын байгууллагын ангилал, стандартад хүргэх</li> </ul>

## БҮЛЭГ ТАВ.

### 5.1. Эрүүл мэнд, спорт, нийгмийн хамгааллын салбар

#### Үндэслэл

Хүн амд 19 сүм 1 тосгон, 15 өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлдэг. Нарийн мэргэжлийн тусламжийг аймгийн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн 5 эмнэлэг, БГХӨТГазар үзүүлж байна.

Эрүүл мэндийн газар нь сүм, тосгон, өрх, нэгдсэн эмнэлгийг мэргэжлийн удирдлагаар хангаж байна. Өнөөдөр тус аймагт 10000 хүнд их эмч 11,6 эмнэлгийн дунд мэргэжилтэн .....оногдож байгаа бөгөөд нарийн мэргэжлийн тусламжийг зөвхөн нэгдсэн эмнэлэг үзүүлж байна.

Эрүүл мэндийн статистик мэдээнээс үзвэл 1000 хүн амд төрөлт 18,9 нас барагт 5,6 цэвэр өсөлт 13,3 байна. Өвчлөл нас барагтын байдлыг авч үзвэл

- I. Амьсгалын замын өвчин
- II. Хоол боловсруулах замын өвчин
- III. Зүрх судасны замын өвчин
- IV. Хорт хавдар байна

Аймгийн хөдөөд 10000 хүн амд 4 их эмч, эмнэлгийн дунд мэргэжилтэн ... оногдож байна. Одоогийн байдлаар бүсийн төв болох Баянцагаан сум их эмчгүй, Богд , Жаргалант, Бууцагаан сум нарийн мэргэжлийн эмчгүйгээс бүх төрлийн нарийн мэргэжлийн тусламж (хагалгаа) аймгийн төвд төвлөрч байгаагаас яаралтай тусламж оройтон, өвчин хүндэрч хугацаа их алдаж байна.

Хүн амьн эрүүл мэндийн боловсролын түвшин хангалтгүй сургалт сурталчилгаа тодорхой стандартгүй , үр дүн тооцох аргачлалгүй, тус үйл ажиллагаанд хамт олны оролцоо сул, ялангуяа аймаг сумаас алслагдсан хүн ам сургалтад бүрэн хамрагдаж чадахгүй байна.

#### Стратегийн зорилт

Стратегийн зорилт 1. Хүний ажиллаж амьдрах эрүүл орчин бий болгох

Стратегийн зорилт 2. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох тогтолцоог боловсронгуй болгон эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлнэ.

Стратегийн зорилт 3. Салбарын хүний нөөцийг хөгжүүлэн хангамжийг нэмэгдүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх нөхцөл боломжийг бий болгоно.

Стратегийн зорилт 4. Орчин үеийн шинжлэх ухааны нээлт шинэ дэвшилтэй технологийг нэвтрүүлэн эмчилгээ оношлогооны чанарыг дээшлүүлэн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны стандартыг хангана.

Стратегийн зорилт 5. Бүх түвшинд хүн амьн эрүүл мэндийг бэхжүүлэн биеийн тамир чийрэгжүүлэлтийн ажлыг дэмжих орчин бүрдүүлнэ.

Зорилт	Үе шат	Үйл ажиллагааны чиглэл
1. Хүний ажиллаж амьдрахад сөрөг нөлөө үзүүлэхгүй орчин бий болгоно.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➢ Баянхонгор сумын гэр хорооллын болон уурын зууханд технологийн шинэчлэлт хийн агаарын бохирдолтыг багасгах</li> <li>➢ Утаагүй түлш үйлдвэрлэх технологи нэвтрүүлж түлш үйлдвэрлэн хангаж эхлэх</li> <li>➢ Орон нутгийн түвшинд хог хаягдлын менежментийн талаар стратеги боловсруулан хэрэгжүүлэх</li> <li>➢ Хүнсний хангамж, чанар, хүртээмж, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>➢ Авто хөгслийн утаан дахь хорт бодисын хэмжээг тогтоосноор зөвлөрөгдхөк хэмжээнээс илүү хорт хий ялгаруулж буй авто хөгслийг ашиглахгүй байх.</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>➢ Үндны усны хангамж сайжруулан ус цэвэршүүлэх, зөвлөрүүлэх, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмжийн хангах</li> <li>➢ Төвийн гэр хорооллын айл өрхийн зарим хөгслийг төвлөрсөн усан хангамж, бохирын шугам сүлжээнд холбох</li> </ul>
2. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох тогтолцоог боловсронгуй болгон эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшшуулэх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлнэ.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➢ Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох тогтолцоог орон нутгийн түвшинд шинэ хэлбэрээр явуулдаг болгох.</li> <li>➢ Сум сум дундын эмнэлэгт эрүүл мэндийн асуудал хариуцсан бага эмч орон тоогоор ажиллуулж 3 хот, 10 айлын дунд сайн дүрүн туслагч ажиллуулах, тэднийг бэлтгэх замаар нийт иргэдийн 40 өөс доошгүй хувьд, эрүүл мэндийн боловсрол эзэмшиүүлэх</li> <li>➢ Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож буй түвшинг тогтоосны үндсэн дээр орон нутгийн онцлогт тохирсон ЭМБО сургалтын стандартыг боловсруулан мөрдүүлэх</li> <li>➢ Нэхөн үржихүйн эрүүл мэнд төслийн дэмжлэгтэйгээр хэвлэлийн цех байгуулан иргэдийг ЭМ ийн сургалтын гарын авлага, сурталчилгааны материалаар хангах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>➢ Эрүүл мэндийн нэвтрүүлэг хийх телевизийн студи байгуулан иргэдэд зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>➢ Хүн амын зан үйлийг өөрчлөх, мэдээлэл сургалт сурталчилгааны нэгдмэл байдлыг сүлжээ үүсгэх замаар сайжруулах</li> </ul>
3. Салбарын хүний нөөцийг хөгжүүлэн хангамжийг нэмэгдүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх нөхцөл боломжийг бий болгоно.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➢ Хөдөө сумдаас ЭМШУИС болон бусад анагаах ухааны дээд сургуульд элсэгчдэд туслалцаа үзүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага хувь хумууст төрөөс дэмжлэг үзүүлэх</li> <li>➢ Аймгийн нэгдсэн эмнэлэгт шаардлагатай байгаа эмгэг анатоми, шүүх эмнэлэг, сэтгэц- наркологи, клиник лабораторийн эмч нарыг бэлтгэх.</li> <li>➢ Аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллагсдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн мэргэжлийн сургач багш нарыг бэлтгэх</li> <li>➢ Азийн хөгжлийн банк, МУ-ын Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй "ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР -2" хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутагт ажиллах эмч эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэн 10000 хүнд оногдох эмчийн тоог улсын дунджаас дээгүүр хэмжээнд хүргэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>➢ Хөдөө сумдаас 20-иос доошгүй оюутныг ЭМШУИС болон анагаах ухааны бусад дээд сургуулиудад гэрээгээр элсүүлэх ажлыг зохион байгуулах</li> <li>➢ Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөгөөнийг жил бүр зохион туршлага солилцон газар дээр нь очин ажил байдалтай танилцдаг уламжлал тогтоох</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>➢ Хөдөө сумдад ажиллаж байгаа эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийг шалгаруулж ЭМШУИС болон анагаах ухааны бусад дээд сургуулиудад сурган орон нутагт тогтворт суурьшилтай ажиллах их эмчийг бэлтгэхэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх</li> </ul>

4. Орчин үеийн шинжлэх ухааны нээлт шинэ дэвшилтэй технологийг нэвтрүүлэн эмчилгээ оношлогооны чанарыг дээшлүүлэн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны стандартыг хангана.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➤ Сумдын эмнэлгийг шаардлагатай компьютер, нарны зайд зэрэг тоног төхөөрөмжөөр ханган, түүн дээр ажиллах боловсон хүчинийг сургах</li> <li>➤ Аймгийн эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сумдын эмнэлгийг компьютерийн сүлжээгээр холбон шаардлагатай мэдээллийг сүлжээгээр дамжуулдаг болох</li> <li>➤ Нэгдсэн эмнэлгийн түргэн тусlamжийн тасгийг компьютерийн сүлжээ, скайнер, дижитал аппарат, зэрэг шаардлагатай төхөөрөмжөөр бүрэн тоноглож яаралтай тохиолдолд клиникин төв эмнэлгийн зөвлөхүүдтэй шууд холбогdon онош тогтоож, эмчилгээг газар дээр нь хугацаа алдахгүйгээр хийх</li> <li>➤ Мэдээллийн сүлжээг ашиглан ЭМГ-т 0-5 хүртэл насны хүүхэд, төрөх насны эмэгтэйчүүдийн санг тус бүр байгуулан өртөмтгийн бүлгийг хянах, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эндэгдлийг эрс бууруулах</li> </ul>
	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➤ Бүсийн төв болох сум дундын эмнэлгүүдийт эмч, тоног төхөөрөмжөөр ханган мэс засал, эх барихын нарийн мэргэжлийн тусlamжыг үзүүлдэг болох</li> <li>➤ Жаргалант сумын эмнэлгийг жишиг эмнэлэг болгон хөгжүүлж, хангайн бүсийн бичил оношлогооны төв болгох</li> <li>➤ Нэгдсэн эмнэлгийн зүрх судасны кабинетийг зүрхний цахилгаан бичлэгийн алсын зайн дамжуулалтын аппаратаар тоноглож, клиникин II эмнэлэгтэй холбогдон зөвлөгөө авдаг болох</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>➤ Дурангийн хагалгааг орон нутагт хийдэг болох нөхцөл бүрдүүлэх</li> <li>➤ Сумдад индикаторийн шинжилгээ хийдэг бичил лабораторитой болох</li> <li>➤ Бүрэн тоноглогдсон чийрэгжүүлэлтийн төвтэй болох</li> <li>➤ ЭЭГ шинжилгээг орон нутагт хийдэг болох</li> <li>➤ Орон нутагт ургадаг эмийн ургамал ашиглан зарим төрлийн эм үйлдвэрлэн эмийн хэрэгцээний 10 аас доошгүй хувийг хангадаг болох</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>➤ Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад оронд мэргэжил дээшлүүлэх талаар төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх</li> <li>➤ Цээжний хөндий, мэдрэлийн мэс засалын мэргэжлийн эмч бэлтгэн энэ чиглэлүүдийн хагалгааг орон нутагт хийдэг болох</li> </ul>
5. Бүх түвшинд хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэн биеийн тамир чийрэгжүүлэлтийн ажлыг дэмжих орчин бүрдүүлнэ.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➤ Спорт цогцолборын хүрээлэн буй орчинг зулэгжүүлэн моджуулах амралтын орчин бүрдүүлэх</li> <li>➤ Үндэсний бэх, морь, сурын спортыг уламжлал шинэчлэлийг хослох үндсэн дээр хөгжүүлэх</li> <li>➤ Улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагт байнга зохион байгуулж спортын шинэ төрлүүдийг хөгжүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>➤ Спортын иж бүрэн үйлчилгээний цогцолбортой болох (усан бассей, гимнастикийн заал, бөхийн өргөө)</li> <li>➤ Олимпизмын үйл ажиллагааг сурталчлан бүх сум, сургуулиудад олимпийн танхимтай болох.</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>➤ Бүх нийтийн биеийн тамирын чиглэлээр албан байгууллага аж ахуй нэгж бүрт спортын иж бүрэн клубтэй болох</li> <li>➤ Нийтийн биеийн тамирын стандартын гадаа талбайтай болох</li> </ul>

## 5.2.ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР

### Хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал

Аймгийн бүртгүүлсэн ажилгүйчүүд 2005 оны 8 сарын эцсийн байдлаар 3153 байна. Нийт ажилгүйчүүдийн 57 хувь нь эмэгтэйчүүд, 54.6 хувийг 15-35 хүртэлх насны залуучууд эзэлж байна.

Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	2001	2002	2003	2004
1.	Бэлэн хүн амын тоо	86460	84364	89937	84304
2.	Хөдөлмөрийн насны хүн амын тоо	45582	48228	49052	49645
3.	Ажиллагсад	35583	31633	34447	36123

4	Хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо	10419	9495	5865	6176
5	Бүртгэлтэй ажилгүйчүүд	1833	2465	2733	3285
6	Ажилгүйдлийн түвшин	4.9	7.2	7.3	8.5
7	Ажилд зуучлагдсан хүний тоо	687	3119	1538	1018
8	Мэргэжил олгох, давтан сургалтанд хамрагдсан хүний тоо	146	357	602	624
9	Нийтийг хамарсан ажилд хамрагсан хүний тоо	125	147	493	504

Аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн гол шалтгаан нь 2002, 2003 онд болсон ган, зуд, байгалийн гамшгийн улмаас хөдөөний иргэд маглүй болж улмаар ажилгүйчүүдийн энээнд шилжих болсонтой холбоотой. Малгүй болсон иргэдийн хөдөлмөр эрхлэлт анхаарал татсан асуудал боллоо. Малгүй болсон ажилгүй иргэдэд хандсан тусгайлсан болдого, арга хэмжээг / малжуулах, МАА-газар тариалан-туслах аж ахуй гэсэн 3-н салбарыг зохистой харьцаагаар хөгжүүлэх / хөдөлмөр эрхлэлтийн дэвшилттэй хэлбэрээр, / өрхийн аж ахуй эрхлэх, хоршоо байгуулах, хэсэг бүлгийн нэгдлээр, нэгэн баг болж ажиллах г.м / тусгай тесэл, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх шаардлага гарч байна

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн дунд хөдөнөөс шилжиж ирсэн мэргэжилгүй заплуучуудаас гадна мэргэжлийн боловсролгүй удаан хугацаагаар ажилгүй байгаа 35 болон түүнээс дээш насын хүмүүсийн тоо өндөр байна. Энэ нь ажил олгогчийн хэрэгцээнд тохирсон мэргэшилтэй, ур чадвартай ажиллах хүчин хомсдолтой байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх явдал юм. Зах зээлийн ерөнхий багтаамжийг аваад үзэхэд газар тариалангийн салбарт бизнесийн орон зай сул чөлөөтэй байгаа нь ажиглагдаж байна

Албан бус хэлбэрээр хөдөлмөр эрхлдэг хүний тоо, албан бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг ААН-ийн тоо ч олшироор байх чиг хандлага ажиглагдаж байна.

Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн байдал ерөнхийдөө ажиллах хүчиний урсгал хөдөлгөөн ихтэй, бүтээмж багатай, зах зээлд ажиллах хүчиний өрсөлдөх чадвар муу, мэргэжилгүй ажилгүйчүүдийн эзлэх хувь өндөр, ажилгүйдлийн үргэлжлэх хугацаа урт гэсэн гол шинж чанараар тодорхойлогдож байна. Хүн амын хэтийн тооцооны таамаглалаас харахад хүн амын өсслөөс хөдөлмөрийн нөөцийн өсслөт дээгүүр буюу жилд 1177-2488 заплуучуудаар сэлбэгдэж, тэднийг ажлын байр, мэргэжилтэй болгох шаардлагатай болж байна.

### Стратегийн зорилт

**Стратегийн зорилт 1:** Хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлогыг хэрэгжүүлэх цогц арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулж ажилгүйдлийн түвшинг 4.0 хувьд хүргэнэ.

Зорилт	Үе шат	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлогыг хэрэгжүүлэх цогц арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулж ажилгүйдлийн түвшинг 4.0 хувьд хүргэнэ.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➢ Ядуу болон бага орлоготой иргэдэд жижиг зээл олгож бизнесийг дэмжин амьдрал ахуйг тэтгэсэн болдого хэрэгжүүлэх</li> <li>➢ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан ажилгүй иргэн, ажил хайгчдыг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах үйл ажиллагааг зохион байгуулах</li> <li>➢ Сум багийн төвд халуун ус, үсчин, оёдол, гутал засвар зэрэг ахуйн үйлчилгээний цэг, салбарыг бий болгоход туслах замаар ажлын байр бий болгох</li> <li>➢ “Нэг баг – нэг шилдэг бүтээгдүүн” хөдөлгөөнийг өргөжүүлэн орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байр бий болгох</li> <li>➢ Ажлын байр шинээр бий болгосон буюу ажилгүй иргэдэд шинээр мэргэжил олгох, мэргэжлийн ур чадварыг дээшшуулэх чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулсан ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх</li> <li>➢ Хоршоо, нэхэрлэл байгуулах, аж ахуй эрхлэх ур чадварын сургалт явуулах, зээл тусламж зэрэг хөрөнгийн эх үүсвэрээр дэмжих замаар иргэдийг ажлын байраар хангахад болон өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд туслах</li> <li>➢ Ажлын байр нэмэгдүүлэх амьжиргааг дээшшуулэхэд чиглэгдсэн олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудын санаал санаачлагыг дэмжин хамтран ажиллах</li> <li>➢ Мэргэжил олгох орон нутгийн сургалтын байгууллагуудыг бий болгон хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжил олгох болон мэргэжлийн ур чадварын сургалтад ажилгүй заплуучууд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамуулж, сургалтын чанар, үр дүнг сайжруулах</li> <li>➢ Бүлэг, хоршоо байгуулах замаар ядуу өрхийн дунд тодорхой хэмжээний мал олгож маллуулах, ногоо тарих,</li> </ul>

		байгалийн дагалдах баялагийг ашиглах, гахай шувууны зэрэг туслах аж ахуй хөгжүүлэх иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжин туслах
		<ul style="list-style-type: none"> <li>➢ Албан бус секторт ажиллагчдад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>➢ Орон нутгийн өвөл, хаврын улиралд цасанд боогддог зам бартаа ихтэй даваа гүвээг засч арчлах, зам засварын хэсгүүдийг байгуулж, ажлын байр бий болгох</li> </ul>
	2011- 2015	<ul style="list-style-type: none"> <li>➢ Мал аж ахуйн гаралтай түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх ажлыг дэмжих замаар иргэдийг түр ажлын байраар хангах</li> <li>➢ Ойн нөөц, усны эх булаг ховордсон ан амьтдыг хамгаалах, ой цэвэрлэх булаг шандыг тохижуулах, ойг нөхөн сэргээхэд орон нутгийн иргэдийг өргөнөөр хамруулж түр болон байнгын ажлын байраар хангах</li> <li>➢ Иргэдийн ажлын бүтэн бус долоо хоног, богиносогон цагаар болон гэрээгээр ажиллуулах хэлбэрийг нэвтрүүлэх, зуучлах үүрэгтэй хөдөлмөр зуучлалын хувийн хэвшлийн байгууллага байгуулах</li> <li>➢ Зээл тусламжийн зарцуулалт, хуваарилалтад жендерийн дүн шинжилгээ хийж ялангуяа жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн бодлого хэрэгжүүлэхийн зэрэгцээ иргэдэд хуримтлал бий болгох сэтгэлгээг төлөвшүүлэх</li> <li>➢ Жижиг бизнес эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, инкубаторын үйлчилгээг хөгжүүлж малчдад явуулын сургалтын үйлчилгээ үзүүлэх</li> <li>➢ Олборлох болон жижиг дунд үйлдвэр, хүн амын ахуйн үйлчилгээг дэмжих, дэд бүтэц, аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тулхүү анхаарах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>➢ Ажил олгогч ба ажиллагчдын хамтын ажиллагааг хөгжүүлж, үйлдэрлэлийн үр дүнг дээшлүүлэх түүний үр дүнг шударгаар хувиарлах хөдөлмөрийн үнэлэмжийг үнэлэхэд чиглэсэн дэмжлэг туслалцаа үзүүлдэг механизмыг бий болгон төлөвшүүлэх</li> <li>➢ Хөдөө орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ялангуяа нүүдэлч малчдын үйлдвэрлэл, хөдөлмөрийн онцлогт нийцүүлэн хөдөлмөр эрхлэлт, амьжиргааг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</li> </ul>

### 5.3 Нийгмийн хамгааллын өнөөгийн байдал

2004 оны байдлаар аймгийн нийт 21315 өрхийн 12017 өрх буюу 56,0 хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх байна. Нийт ядуу өрхийн 42393 хүн амын 14593 хүн ам буюу 34,4 хувь нь халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмжинд хамрагдаж, 2000 онтой харьцуулахад 60 хувиар нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр тэтгэмжинд зарцуулсан 958275,7 мянган төгрөгийг 2000 онтой /454974,1/ харьцуулбал 2 дахин нэмэгдсэн боловч нэг хүнд ноогдох хүртээмж бага, эмзэг бүлгийн иргэдийн амьдралд үзүүлэх нөлөө муу, бэлэнчлэх сэтгэлгээг бий болгосон, ядуу эмзэг бүлгийн гишүүн болох сонирхолтой хүний тоо өсөх хандлагатай байна. Мөн нийгмийн халамж, тусламж үйлчилгээнд хамрагдах бүлгүүдийг зөв тодорхойлдоггүй, өрх, нийгэм хамт олонд тулгуурласан халамж үйлчилгээг хөгжөөгүй, нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн аж байдлыг дээшлүүлэх үйлчилгээний чанар, үр дүн хангалтгүй байгаа юм.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгал албан бус салбарт ажиллагсад болон малчдын .... хувь даатгуулсан байна.

#### Стратегийн зорилт

**Стратегийн зорилт 1:** Эмзэг бүлгийнхэн /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд/-ний орлогыг нэмэгдүүлэх, нийгэмшүүлнэ

**Стратегийн зорилт 2.** Нийгмийн халамжийн сангуудаас олгож буй тэтгэмжийн нэр төрөл, хэлбэрийг оновчтой болгох замаар ядуу болон нэн ядуу өрхийн амьжиргааг дэмжих, тэдгээр өрхийн гишүүдийн амьжиргааг бие даан авч явах чадавхийг сайжруулах

**Стратегийн зорилт 3** Нийгмийн даатгалд хамрагдагсдын хүрээг өргөжүүлэн иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах

<b>Зорилт</b>	<b>Үе шат</b>	<b>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа</b>
Эмзэг бүлгийнхний орлогыг нэмэгдүүлэх, нийгэмшүүлнэ.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн Хөдөлмөрийг устгах Олон Улсын Хөтөлбөрийн Монгол дахь төлөөлөгчийн газар болон Улсын Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтарч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх</li> <li>➤ Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн талаарх мэдээллийн тогтолцоог бурдуулж тэдгээр хүүхдүүдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээгээр дамжуулан дэмжих үйлчилгээг сайжруулах нөхцөл бололцоог судлах</li> <li>➤ Тахир дутуу иргэдэд мэргэжлийн чиг баримжaa олгох болон ур чадварыг хөгжүүлэх, хувиараа болон аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөр эрхлэхийг дэмжихэд чиглэгдсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>➤ Ахмад настнуудын хуримтлуулсан ажлын дадлага туршлагыг үр ашигтай ашиглах, өөрсдийг нь нийгмээс хөндийрүүлэхэд чиглэгдсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хүүхэд, запуучуудыг үйлдвэрлэлийн дадлагад хамруулан амьдрах арга ухаанд сургах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх</li> <li>➤ Эмзэг бүлгийн иргэдийг бизнес эрхлэн бие даан амьдрах мэдлэг, дадлага олгох сургалтуудыг зохион байгуулан ядуурлаас гарахад иргэд өөрсдөө тэмцдэг үзэл баримтлалыг төлөвшүүлэхэд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог дэмжих</li> <li>➤ Гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлыг хөгжүүлэн, хүүхэд хамгааллын асуудлаар мэргэжлийн зөвлөгөөг өргөжүүлэх</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийг сургуульд нь буцаах, тэдний оронд эцэг эх асран хамгаалчийг нь хөдөлмөр эрхлэлтийн дэмжих үйлчилгээнд нөхцөлтэйгээр хамруулах, хөдөлмөрийн нас ойртсон хэсэгт нь мэргэжлийн баримжaa олгоход чиглэгдсэн хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийг хөдөлмөрөөс нь ангижруулах хөтөлбөр хэрэгжүүлэх</li> <li>➤ Гэр бүлийн гишүүд, запуучууд болон хүүхдүүдэд бага нааснаас нь нийгмийн үнэт зүйлс, ёс суртахуун, зан төлөвшлийг бий болгон, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахад дэмжкин туслах үйл ажиллагааг хөгжүүлэх</li> </ul>
Нийгмийн халамжийн сангугудаас олгож буй тэтгэмжийн нэр төрөл, хэлбэрийг оновчтой болгох замаар ядуу болон нэн ядуу өрхийн амьжиргааг дэмжих тэдгээр өрхийн гишүүдийн амьжиргаагаа бие даан авч явах чадавхийг сайжруулна.	2005-2010	<ul style="list-style-type: none"> <li>➤ Нийгмийн халамжийн үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэх замаар төлөвшүүлэх</li> <li>➤ Нутаг дэвсгэрийн хэмжээнд халамжийн үйлчилгээнд судалгаа дүгнэлт хийж, төлөв байдал чиг хандлагыг тодорхойлон, нэр төрөл тоо хэмжээг тодорхойлох</li> <li>➤ Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл боломжийн талаар иргэдэд хууль тогтоомжийн зөвлөгөө өгөх</li> <li>➤ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>➤ Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний талаарх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд халамжийн тэтгэвэр тэтгэмжид хамруулах талаарх, мэн хүүхдийн тэтгэлэгийн талаарх хууль тогтоомж, төрийн бодлого нутгийн удирдлагын шийдвэрийг аймгийн хэмжээнд зохион байгуулж тайллагнах, хөрөнгө хуваарилах, мэдээллийн сан бурдуулж, баримт бичгийн архивын нэгж бурдуулж</li> <li>➤ Нийгмийн түншлэл нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулах мэдээлэл солилцох ажлыг удирдан зохион байгуулах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>➤ Тэтгэвэр тэтгэмжийн сан, нийгмийн тусгай сан, амьжиргаа дэмжих сан, нэн эмзэг хүмүүст зориулсан төвлөрсөн үйлчилгээний сангудын үйлчилгээний нэр төрөл чиглэлийг тогтоож хэрэгжүүлэх</li> </ul>

## БҮЛЭГ ЗУРГАА.

### Төрийн байгууллагын шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд баримтлах чиглэл

#### Үндэслэл:

2005 онд аймгийн хүн амын 12.2 хувь дипломын болон түүнээс дээш боловсролтой, 19.1 хувь нь бүрэн дунд болон мэргэжлийн боловсролтой, 23.8 хувь нь бүрэн бус дунд, 20.5 хувь нь бага, 24.4 хувь нь боловсролгүй байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 3333 төрийн албан хаагч ажиллах байгаагийн 142 нь улс төрийн, 281 нь захиргааны, 156 нь төрийн тусгай, 2754 нь төрийн үйлчилгээний албан хаагч байна. Төрийн албан хаагчийн 928 буюу 27,8 хувь нь бакалаврын болон түүнээс дээш зэрэг цолтой, 1255 буюу 37,6 хувь нь дипломын боловсролтой байгаа нь нийт төрийн албан хаагчдын 66,1 хувь нь болж байна.

Сумдын Засаг даргын Тамгын газрууд болон бусад төрийн байгууллагуудын ажлын байрны хүрэлцээ, нэхцэл хангалтгүй, нийт төрийн албан хаагчдын 10 хүрэхгүй хувь нь компьютер техник хэрэгслээр хангагдсан байна.

#### Стратегийн зорилт:

- 1.Хүний хөгжлийн чадавхийг хангах боловсон хүчин бэлтгэх, зөв байршуулах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- 2.Төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулах, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, ажиллах нэхцэл баталгааг сайжруулах
- 3.Төрийн байгууллагуудын ажлын байрны нөхцлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх, мэргэжлийн байгууллагуудыг шаардлагатай техник зэвсэглэмжээр хангах
- 4.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны шинэчлэлтийг гүнзгийрүүлэх

Зорилт	Ye шат	Үйл ажиллагааны чиглэл
1. Хүний хөгжлийн чадавхийг хангах боловсон хүчин бэлтгэх, зөв байршуулах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх	2006-2010	<ul style="list-style-type: none"><li>• Дээд боловсрол эзэмшиүүлэх болон мэргэжилтэй ажилтан бэлтгэх тоог нэмэгдүүлж, жилд ... –с доошгүй дээд боловсролтой, ....-с доошгүй мэргэжилтэй ажилтан бэлтгэх</li><li>• Төв, хөдөөгийн сургуулиудыг мэргэжлийн багшаар бүрэн хангах</li><li>• Аялал жуулчлалын болон газрын гүний дулааныг ашиглах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх</li><li>• ХАА-г эрчимжсэн байдлаар хөгжүүлэхэд туслах мэргэжилтний орон тоог сум бүрт ажиллуулах</li></ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"><li>• Хөдөөгийн багуудыг дээд мэргэжлийн эмчээр хангах</li></ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"><li>• Аймагт 5-аас доошгүй дээд сургуультай болсоон байх</li><li>• Арьс шир, ноос ноолуур гэх мэт боловсруулах чиглэлийн үйлдвэрт ажиллах мэргэжилтнүүд бэлтгэгдсэн байна.</li></ul>
2. Боловсон хүчин бэлтгэх, зөв байршуулах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх		<ul style="list-style-type: none"><li>• Аймагт 5-аас доошгүй дээд сургуультай болсон байна.</li><li>• дээд боловсрол эзэмшиүүлэх болон мэргэжилтэй ажилтан бэлтгэх тоог нэмэгдүүлж, жилд .. с доошгүй дээд боловсролтой, ... с доошгүй мэргэжилтэй ажилтан бэлтгэсэн байна.</li><li>• төв, хөдөөгийн сургуулиудыг мэргэжлийн багшаар бүрэн хангана</li><li>• хөдөөгийн багуудыг дээд мэргэжлийн эмчээр хангана.</li><li>• аялал жуулчлалын болон газрын гүний дулааныг ашиглах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэгдсэн байна.</li><li>• боловсруулах чиглэлийн үйлдвэрт ажиллах мэргэжилтнүүд бэлтгэгдсэн байна. /Арьс, шир, ноос ноолуур, мах гэх мэт/</li><li>• ХАА-г эрчимжсэн байдлаар хөгжүүлэхэд туслах мэргэжилтний орон тоог сум бүрт ажиллуулах</li><li>• Яам бүрт газрын дарга болон түүнээс дээш албан тушаалд аймгийн үндсэн боловсон хүчин ажилладаг болсон байна.</li></ul>

3. Төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулах, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, ажиллах нөхцөл баталгааг сайжруулах	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>• төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, тавигдах шаардлагыг өндөржүүлэх</li> <li>• төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь суралцах боломж нөхцлийг бүрдүүлэх</li> <li>• Аймгийн ЗДТГ-т сургалтын төв байгуулах</li> <li>• Төрийн албаны стандартыг хэлбэрэлтгүй сахиж мөрддөг болгох</li> <li>• төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>• мэргэжил мэргэшлээ дээшлүүлэхэд нь зориулж байгууллагын зүгээс үзүүлдэг санхүүгийн дэмжлэг туслалцааг өргөтгөх</li> <li>• хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх</li> <li>• төрийн байгууллага бүрийн үйл ажиллагааны дотоод дэг журмыг сайжруулах</li> <li>• төрийн байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох ажлыг өргөжүүлэх</li> <li>• төрийн бүх шатны байгууллагын албан тушаалын ажлын байрыг мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлэх.</li> <li>• Аймаг, сум, байгууллага, салбарын түвшинд төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>• Суманд ажиллаж байгаа цагдаагийн ажилтнуудыг 100 хувь төрийн мэдлийн байраар хангах</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албаны бүх ажлын байрыг бүртгэгдсэн нөөцтэй болгох</li> <li>• Төрийн жинхэнэ албан хаагчдыг хос мэргэжил эзэмшиүүлж, хөрвөж ажиллах чадварыг сайжруулах</li> <li>• Ажлын байрны нөхцлийг сайжруулж, шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангах</li> </ul>
	2016-2020	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, сум, байгууллага, салбарын түвшинд төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>• Төрийн албан хаагчдын гэр бүлийг дэмждэг хөшүүргийг бий болгох</li> <li>• Цагдаагийн байгууллагад 5, Шүүх, Прокурор, ШШГА, ОБХ зэрэг байгууллагад тус бүр 3-аас доoshgүй төрийн мэдлийн орон сууцтай болгох бэлтгэх</li> </ul>
4. Төрийн байгууллагуудын ажлын байрны нөхцлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх, мэргэжлийн байгууллагуудыг шаардлагатай техник зэвсэглэмжээр хангах	2006-2010	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгийн асуудлыг жил жилийн төсөвт тусгах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар төрийн албаны ажлын байрны асуудлыг шийдвэрлэх</li> <li>• Сумдын ЗДТГ-дын халаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэх</li> <li>• Нутгийн захирагааны болон төрийн байгууллагуудын ажилтан бүрийг орчин үеийн ширээ сандал, техник хэрэгслээр хангах, компьютержүүлэх</li> <li>• Багийн албыг компьютержүүлэх</li> <li>• Цагдаагийн ажилтан бүрийг нэг бүрийн хөдөлгөөнт холбоо, бусад хэрэгслээр хангах</li> <li>• Гал унтраах болон аврах тоног зэвсэглэмжийг шинэчлэх</li> <li>• Багийн Засаг дарга нарыг унаатай, чанга яригчтай болгох</li> </ul>
	2011-2015	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн архивын тасгийн ажлыг цахим үйлчилгээнд шилжүүлэх</li> <li>• Төрийн байгууллагуудын төсвийг хүрэлцээтэй болгох</li> </ul>

		<b>2016-2020</b>	<ul style="list-style-type: none"> <li>Сум, байгууллагаас авах мэдээ тайлан, статистик мэдээ мэдээллийг цахим сүлжээгээр авдаг болох</li> <li>Байгууллагууд дотооддоо /байгууллагын сүлжээ-LAN/ болон ажил төрлийн уялдаа бүхий байгууллагууд хоорондоо /хот доторхи сүлжээ NAN тодорхой радиустай ойрын зайнаас орох сүлжээ/, сумтай Интернет сүлжээ-WAN бус нутгийн сүлжээгээр холбогдох</li> <li>Байгууллагуудыг цагдаа, гамшигийн штабтай холбогдох дохиоллын системтэй болгох</li> <li>Цагдаагийн хэлтэс, ШШГА, ОБХ зэрэг байгууллагуудыг үйл ажиллагааны онцлогт нь тохируулж тусгай тоноглосон автомашинаар хангах</li> </ul>
			<ul style="list-style-type: none"> <li>Прокурорын байгууллагын байрыг шинээр барих</li> <li>Төрийн архивыг зориулалтын тусгай байртай болгох</li> <li>Сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг ээлж дарааллаар шинэчилж барих, засварлах</li> <li>Төрийн байгууллагуудын ажлын байрыг цайны газар, чийрэгжүүлэлтийн танхимтай болгох</li> <li>Гамшигаас хамгаалах хэлтсийн галын автомашинуудыг шинэчлэх, туулах чадвар сайтай тоноглол бүхий автомашин, чаргатай болгох</li> <li>Гамшигаас хамгаалах нөөцийн санг хүрэлцээтэй болгох</li> </ul>
5. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны шинэчлэлтийг гүнзгийрүүлэх	<b>2006-2010</b>		<ul style="list-style-type: none"> <li>ард иргэдийн дунд тодорхой сэдвүүдээр санал асуулга авдаг журмыг нэвтрүүлэх.</li> <li>Иргэдээс санал хүсэлт хүлээн авах хайрцаг, харилцах утас, цэгийг гудамж талбайд байршуулах.</li> <li>Төрийн байгууллага бүр веб хуудастай болж, Веб хуудсаар иргэдийн санал хүсэлтийг авдаг болох.</li> <li>Төле бага хурал, интернет чаатаар харилцдаг болгох.</li> <li>Төрийн бус байгууллагын хүчийг ашиглан нийгмийн сэтгэлгээ, эрэлт хэрэгцээг судалдаг, дүгнэлт шинжилгээ хийдэг чиг үүрэг бүхий бүтэц, орон тоог бий болгох</li> <li>хууль тогтоомж сурталчлах, эрх зүйн сургалт явуулахад шаардлагадах зардлыг нутгийн захиргааны байгууллагын жил жилийн төлөвлөгөөнд тусгах байх.</li> <li>төрийн байгууллагад хандаж иргэдээс гаргадаг бүх төрийн үйлчилгээний маягтыг нэгдсэн загвар, түүнийг бөглөх аргачлалын хамт гаргаж шаардлагатай газруудад байршуулах.</li> <li>Телбэрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийг аймгийн Засаг даргын Тамгын газарт байгуулах.</li> </ul>
	<b>2011-2015</b>		<ul style="list-style-type: none"> <li>бүх албан байгууллага, багуудад эрх зүйн мэргэшсэн сургач нарыг орон тоогоор бэлтгэж, шаардлагатай гарын авлага материал, тоног төхөөрөмжөөр хангах.</li> <li>Нутгийн захиргааны болон төсөөвт байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн цахим сүлжээтэй болгож, төрийн гол гол үйлчилгээг электрон хэлбэрээр үзүүлдэг болгох</li> <li>Сумдад сургалтын танхим байгуулж байнгын ажиллагаатай болгох</li> <li>Багуудыг хууль тогтоомжийн иж бүрэн цахим сантай болгох</li> </ul>
	<b>2016-2020</b>		<ul style="list-style-type: none"> <li>Иргэдэд зөвлөгөө өгдөг чиг үүрэг бүхий төвүүдийг сумдад байгуулах</li> <li>Орон нутгийн телевизийн нэвтрүүлгийг хөдөөд гаргадаг болгох</li> <li>Сумдад интернэтийн үйлчилгээг бий болгох</li> </ul>
6. Иргэний нийгэмтэй харилцах харилцаанд чанарын өөрчлөлт гаргана	<b>2006-2010</b>		<ul style="list-style-type: none"> <li>Төрийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх явдлыг эрс нэмэгдүүлэх</li> <li>Нийгмийн тусын тулд ажилладаг төрийн бус байгууллагад санхүү, зохион байгуулалтын дэмжклэг үзүүлэх үйл ажиллагааг өргөтгэх</li> </ul>
	<b>2011-2015</b>		<ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн тусын тулд ажилладаг төрийн бус байгууллагуудыг нэгдсэн түрээсгүй байранд байршуулах</li> </ul>
	<b>2016-2020</b>		<ul style="list-style-type: none"> <li>төрийн бус байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох</li> </ul>

## БҮЛЭГ. ДОЛОО

### Хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх түвшин.

Манай аймаг энэхүү хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлснээр ойрын 15 жилийн хугацаанд дараах үйл ажиллагааны үр дүнд хүрэх зорилт тавьж байна.

#### НЭГ. Эдийн засгийн чадавхийг сайжруулж ядуурал, ажилгүйдлийг бууруулах зорилтыг ханган биелүүлэх үйл ажиллагааны хөгжил

1. Макро эдийн засгийн өсөлтийг 30 хувиар нэмэгдүүлсэн байна.
2. Дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд ноогдох жилийн дундаж өсөлтийг 4 дахин нэмэгдүүлнэ.
3. Ажилгүйдлийн түвшин 2020 онд .... хувиар буурч ажил эрхлэгчдийн эзлэх хувийн жинг ..... хувиар нэмэгдүүлнэ.

#### ХОЁР. Жижиг дунд үйлдвэр, дэд бүтэц, хот байгуулалт, аялал жуулчлалыг хөгжүүлэх салбарт

##### 1. Жижиг дунд үйлдвэрийн салбарын хөгжил

1. Барилгын материалын хуучин үйлдвэрүүд сэргэж шинээр цемент шохойн үйлдвэр, хүрмэн гулдмайн үйлдвэр, ханын хөнгөн бетон дүүргэгч үйлдвэрүүд ажиллана.

2. Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах чиглэлээр ноос, ноолуур угаах, анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр аймгийн төвд ашиглалтанд орж, цөцгийн тос үйлдвэрлэх, сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрүүд аймгийн төв зарим сумдад ажиллана.

Хиам, консервны жижиг үйлдвэр аймгийн төвд ажиллана. Ингэний ундаа, рашаан савлах үйлдвэр аймгийн төв, Шаргалжуут тосгонд ажиллана. Тэмээний ноос боловсруулах, бод, багийн арьс шир боловсруулах, хонины ноос боловсруулж эсгий, эсгий эдэлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүд аймгийн төв зарим сумдад үйл ажиллагаа явуулна. Мөн баг малын өлөн гэдэс боловсруулж экспортод гаргадаг жижиг үйлдвэр аймгийн төвд ажиллана.

3. Баянхонгор аймгийн нэртэй шилдэг брэнд бүтээгдэхүүн бий болж дотоод, гадаадын зах зээлд гаргадаг болно.

4. Чацарагана, чихэр өвс тарималжуулан эмийн ургамал үйлдвэрлэх жижиг үйлдвэр байгуулагдан ажиллана. Эхийн голын жанцай зэрэг ургамлаар бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүн зах зээлд тогтмол нийлүүлэгдэнэ. Импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.

5. Хүнсний үйлдвэрүүдийн техник технологи сайжирч хүчин чадал нэмэгдэн чанартай бараа бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг найдвартай хангадаг болж сав, баглаа боодлын жижиг үйлдвэр үйл ажиллагаа явуулна. Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл түлхүү хөгжик эрүүл ахуйн шаардлага хангасан ундаа, жүүс, иоджуулсан давс зэрэг зайлшгүй хэрэглээний гол нэрийн жижиг үйлдвэрүүд бий болно.

6. Хүнсний стандарт чанарыг хянан баталгаажуулах лаборатори байгуулагдан өндөр мэдрэмжтэй хромотограф, атом шингээлтийн спектрофотометрийн аргад шилжин ажиллах болно.

##### 2. Дэд бүтцийн салбарын хөгжил

-Өвөрхангай-Баянхонгорын хооронд хатуу хучилттай зам бүрэн тавигдана

-Баянхонгор хотын доторхи замууд сайжирч төв урсгалаас салбарласан хатуу хучилттай замын хэмжээ нэмэгдэнэ.

-Цэвэр усны байгууламжийн хэвийн ажиллагаа бүрэн хангагдаж үйлдвэр үйлчилгээ явуулахад цэвэрлэх байгууламж найдвартай ажиллана.

-Эрчим хүчин систем хэвийн үйл ажиллагаа явуулж аймгийн төвийн эрчим хүчиний цахилгаан тоног төхөөрөмж бүрэн шинэчлэгдэнэ. 10 сум төвийн эрчим хүчиний нэгдсэн сүлжээнд холбогдоно. Мөн 6 сум сэргээгдэх эрчим хүчээр холбогдоно.

-Хөдөөгийн малчин өрхүүд сэргээгдэх эрчим хүчээр бүрэн хангагдсан байна.

-Холбоо мэдээллийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж дараахь үр дүнд хүрнэ.

	2010 онд	2015 онд	2020 онд
1. Суурин телефоны цэгийн тоо	2400	2600	3000
2. Үүрэн телефон хэрэглэгчийн тоо	25 хувь	30 хувь	40 хувь
3. Интернетийн үйлчилгээнд хамрагдах хүн ам	25 хувь	40 хувь	60 хувьд тус хүрсэн байна.

Барилга хот байгуулалтын хувьд аймгийн төвийн өнгө үзэмж сайжирч шинээр орон сууцны хорооллууд бий болж, 4-р арван жилийн сургууль, ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэг, 5 одтой зочид буудал зэрэг олон барилга байгууламжийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид хамтран байгуулж хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжил бий болж мод зүлэг тарьж суулгах ажлууд жил бүр хийгдсэнээр аймгийн төвийг ногоон бусийн хэмжээнд хүргэх зорилт биелэгдэх нөхцлийг бий болгосон байна.

Аялал жуулчлал хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлснээр аймгийнхаа байгалийн үзэсгэлэнт газруудад тогтмол үйл ажиллагаатай аялал жуулчлалын баазуудыг ажиллуулж Шаргалжуут рашаан сувиллыг түшиглэсэн олон улсын эмчилгээ, амралт сувиллын төв байгуулан үйл ажиллагаа явуулна.

#### ГУРАВ. Боловсролын салбарын хөгжил

- ЕБС 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжсэн байна.

- Мэргэжлийн багшийн хангалт 100 хувьд хүрнэ
- ЕБС-ийн хамран сургалтыг 98 хувьд, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 70 хувьд хүргэнэ
- Сургууль завсардалтын индексийг 0,1 хувьд хүргэнэ.
- Дотуур байранд суух малчдын хүүхдийг 100 хувь хамруулан, байрны хүчин чадлыг 90-100 хувь ашиглана
- Стандартад нийцсэн сургалтын хөтөлбөртэй болно.
- Соёл урлагийн салбараар үйлчлүүлэгчид 800-900 мянгад хүрнэ
- Соёл урлагийн салбарын орлого 30-40 саяд хүрнэ
- Мэргэжилтэй уран бүтээлч соёлын ажилтны тоо 200 хүрнэ

**ДӨРӨВ. Мал аж ахуй, газар тариалан, байгаль орчин газрын харилцааны хөгжил**

**Хөдөө аж ахуйд:**

1.Нутгийн шилмэл үүлдэр омгийн малаар сайжирсан мал сүргийн тоо толгой нийт сүргийн 50-иас доошгүй хувьд хүрч, төвлөрсөн суурингийн ойролцоо саалийн механиксан ферм, гахай, тахиа, махны чиглэлийн үхэр хонины аж ахуйнууд бий болж мах, сүү, өндөгийг үйлдвэрийн аргаар боловсруулж хүнсэнд нийлүүлдгэ тогтолцоо бүрдэнэ.

2.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн тоо нэмэгдсэнээр ажил үйлчилгээний ерсөлдөөн бий болж ажлын чанар хүртээмж сайжирна.

3.Мал эмнэлгийн үйлчилгээ малчдад ойртож урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо өсөж халдварт паразит өвчний гаралт буурах нөхцөл бүрдэнэ.

4.Мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн материаллаг бааз, тоног төхөөрөмжийн хангамж сайжирч стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдтэй болно.

5.Газар тариалангийн бүтээгдэхүүний хэмжээ 2005 оны түвшингээс 6,5 дахин нэмэгдэж төмс, хүнсний ногоогоор аймгийн хүн амын хэрэгцээг бүрэн хангадаг болно.

6.Эмийн болон чухал таримлаар үйлдвэрлэх экспортын бүтээгдэхүүний нэр төрөл 15-аас доошгүй болно.

**Байгаль орчин, газрын харилцааны салбарт.**

1. Аймгийн төв болон бусад төв суурин газарт мод, бут сөөг тарьж ногоон бүсийн хэмжээг 450 га-с доошгүй талбайд байгуулж тарьц, суулгац 500 мянган ширхэгийг ургуулна. Заган болон шинэсэн ойг нутгийн иргэдэд дундын хэлбэрээр эзэмшүүлэх, тэдний хүчээр хамгаалах ажиллагааг нийт ойн 20 хувьд хийсэн байна.

2. Эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг 100 хувь бүрэн хийлгэж, алт, нүүрс, зэс молибдены болон бусад ашигт малтмалын нөөцийг аж ахуйн нэгж байгууллагуудын хайгуул судалгааны үндсэн дээр тогтоолгоно.

Байдраг, Түйн голын ай сав газарт ашиглалт явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дуусгаж нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэж жимсний мод тарих ажлыг төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ.

3. Эрдэжилт, хатуулаг яхтэй ус хэрэглэдэг сумдын уст цэгүүдэд 100 % ус цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулна.

Томоохон голуудын ай савын зөвлөл байгуулж хамгаалалтанд авах, 70-аас доошгүй булаг шандын эх ундаргыг хашиж хамгаалан журам гарган мөрдүүлнэ.

Гадаргын усны урсацыг тохишуулах, гадаргын усны ашиглалтыг 50 хувь хүртэл нэмэгдүүлнэ. Аймгийн хэмжээнд ус ашиглагчдын 80 хувь нь цэвэр усаар хангагдсан байна.

4. Аймгийн хэмжээнд ховор, нэн ховор ургамлын нөөцийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, ашигт эмийн ургамлуудын судалгаа хийж гадаад улс орон болон дотоодын хэрэгцээг хангана. Ховордсон амьтадын тооллогыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулан, хамгаалах менежментийг боловсронгуй болсон байна.

5. Хийн тулш хэрэглэх замаар орчны болон агаарын бохирдолгүй болж, хог хаягдалыг ялгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулж, хог хаягдалын менежментийг боловсронгуй болгох хөтөлбөрийг хэрэгжүүлж дуусгана.

6. Мэдээллийн сангийн бодит байдал дээшилж орчин үеийн техник технологоор мэргэжлийн өндөр түвшинд боловсруулсан үнэн зөв баталгаатай мэдээллийн сан бий болж улсын мэдээллийн сантай холбогдсон байна. Газрын харилцааны чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлэхэд зайлшгүй шаардагдах программ хангамж, техник тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хучний чадавхийг дээшлүүлсэн байна.

7. Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд өмчлүүлэх боломжтой нийт газрын 80 хувийг иргэдэд хүсэлтийнх нь дагуу өмчлүүлэх ажлыг зохион байгуулах

Орчин үеийн нарийвчлал бүхий гео багаж, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаж эзэмшил ашиглалт, өмчлөлд байгаа газарт төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг бүрэн хийлгэсэн байна. Баруун болон төвийн бүсүүдийн нутгуудын суурин GPS-ийн сүлжээнд хамрагдана.

**8. Үзэсгэлэнт байгаль – экологийн болон эдийн засгийн хувьд онцгой чухал ач холбогдол бүхий газар, газар нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтанд авч нийт нутаг дэвсгэрийн .... хувийг хамруулна**

**9. Хотыг хөгжүүлэх чиг хандлагыг тодорхойлон газар зүйн онцлог, нийгэм эдийн засгийн ач холбогдол, ариун цэвэр эрүүл ахуйн нөхцлийг харгалzan төлөвлөгөөтэйгээр газар олголтыг явуулж орчин үеийн тохилог хот бий болгох нөхцөл, суурь бүрэн тавигдсан байна. Суурьшлийн бус газрыг тодорхой чиг үүрэг бүхий дэд бус буюу функционоль бүсүүдэд хуваарилах замаар ашиглана.**

**10. Тариалангийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах замаар эрхийг баталгаажуулан гэрээг жил бүр дүгнэх, хүсэлтийн дагуу тариалангийн талбайг үнээр нь худалдан өмчлүүлнэ. Хадлангийн талбайд газар зохион байгуулалтын арга хэмжээ авч, бэлчээрийн зохих ургацтай хэсгийг хадлангийн талбай болгон хадлан авах бололцоотой талбайг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулж, бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бус нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалzan гэрээний дагуу эзэмшүүлнэ**

**11. Газрыг хамгаалах нөхөн сэргээх сан байгуулан газрын төлбөрийн 30-аас доошгүй хувийг төвлөрүүлэн газрыг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна.**

**Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгоно**

**Тариалангийн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа этгээд хөрсийг хамгаалах, түүний үржил шимийг бууруулахгүй байх арга хэмжээ байнга авч газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгэн Монгол улсын иргэнд нийт талбайн 50 %-г өмчлүүлсэн байна.**

**12. Агаар чанарын харуулыг агаар, хөрс, усны бохирдолын лаборатори болгон өргөтгэж, цаг уур ус судлалын өртөө харуулын хөтөлбөрийг гүнзгийрүүлэн Байгаль орчинд гарч байгаа хувирал өөрчлөлтийг судлан тогтооход чиглэсэн ажлыг өргөтгөнө. Ус судлалын харуулыг 3-аар нэмэгдүүлж, гүний усны ажиглалтын сүлжээг бий болгоно.**

**13. Цаг уурын өртөөнүүдэд автомат цаг уурын станц тавьж, Цаг уурын салбаруудыг нэгдсэн холбооны сүлжээтэй болгож, Ус цаг уурын орчны шинжилгээний бүх мэдээллийг цахим хадгалуурт шилжүүлэн, Баянхонгор аймгийн уур амьсгалын 2-р лавлах ботийг зохиож хэвлүүлнэ.**

#### **ТАВ. Эрүүл мэнд, спорт, нийгмийн хамгааллын салбар**

##### **Эрүүл мэндийн салбар:**

- Халдварт өвчний бууралт 62,3
- Эхийн эндэгдэл 10000 амьд төрөлтөд 65%
- Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 20,5 промильд тус тус хүргэнэ.
- Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдагсадын хувийн жинг багасгаж, ядуу өрхийн тоо 2004 оныхоос нэг дахин буурсан байна.
- Сайн дурын нийгмийн даатгалд албан бус салбарт ажиллагсад болон малчдын 50 хувь нь хамрагдсан байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний үр дүнд эдийн засгийн идэвхтэй хүн амаар тооцсон ажилгүйдлийн түвшин 4.0 хувь хүрсэн байна.

\*Дундаж наслалт 1,5 аар нэмэгдүүлнэ.

\*Перинаталь эндэгдэл 1000 амьд төрөлтөд 20 промиль

**\*Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн салбар:**

##### **ЗУРГАА. Төрийн байгууллагын шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд баримтлах чиглэлийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн**

- Аймгийн хүн ам 95628 болсон байх бөгөөд энэ хугацаанд хүн амын боловсролын түвшин одоогийнхоос 10 хувиар дээшилсэн байна.
- Төрийн албан хаагчдын 85-аас доошгүй хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, төрийн жинхэнэ албан хагчдын 70-аас доошгүй хувь нь орос, англи хэлийг эзэмшиж чадсан, 50-иас доошгүй хувь нь хос мэргэжил эзэмшиж бусад ажлын байранд хөрвөж ажиллаж чаддаг болсон байна.
- Төрийн зонхилох байгууллагууд дотоод болон байгууллага хоорондын мөн интернетийн сүлжээнд холбогдон ашигладаг болсон байна.
- Төрийн бүх байгууллагууд дотоод болон байгууллага хоорондын мөн интернетийн сүлжээнд холбогдон ашигладаг болсон байна.
- Гэмт хөргийн гаралтыг одоогийнхоос 20-оос доошгүй хувиар бууруулсан байна.



